



## Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Хөдөө аж ахуйн их сургуулийн  
Агроэкологийн сургууль

Сургалтын хөтөлбөрийн нэр: Байгаль орчныг хамгаалах технологи

Индекс: D071201

2018 оны 02-р сарын 09

<b>Товчилсон үгийн тайлбар</b>	
<b>I. Магадлан шинжлэх үйл явц, төлөвлөлт</b>	<b>4</b>
<b>II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга</b>	<b>5</b>
<b>III. Мэргэжлийн зөвлөлийн тодорхойлолт /хавсралтаар/</b>	
<b>IV. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт</b>	<b>6</b>
Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт	6
Шалгуур 2: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	10
Шалгуур 3: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	13
Шалгуур 4: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	21
Шалгуур 5: Багшийн үйл ажиллагаа	26
Шалгуур 6: Сургалтын үйл ажиллагаа	32
Шалгуур 7: Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө	36
Шалгуур 8: Чанарын үнэлгээ, баталгаажилт	39
<b>V. Шинжээчийн багийн ажлын төлөвлөгөө</b>	<b>41</b>
<b>VI. Оролцогчдын нэрс</b>	
I. Ярилцлагад оролцсон багш нарын нэрс	42
II. Оюутны нэр	42
III. Ажил олгогч	43
IV. Төгсөгчид	44
<b>VI.1 Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал</b>	<b>45</b>
<b>VIII. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр</b>	
<b>IX. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр</b>	

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН – Аж ахуй нэгж

АЭС – Агроэкологийн сургууль

БЗД – Баянзүрх дүүрэг

БЦГ – Байгалийн цогцолборт газар

БОХТ - Байгаль орчныг хамгаалах технологи

БОНС – Байгаль орчны нөхөн сэргээлт

БОНУ – Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ

БОНХАЖЯ – Байгаль Орчин Ногоон Хөгжил Аялал Жуулчлалын Яам

ГБ - Гэрээт багш

БСШУСЯ – Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яам

ШУА – Шинжлэх Ухааны Академи

МҮОНРТ – Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз

МУИС – Монгол Улсын Их Сургууль

ХБЦГ – Хустайн Байгалийн Цогцолборт Газар

УНБУ – Ургамлын нөөц биоүйлдвэрлэл

УНМ – Усны нөөцийн менежмент

УМС – Удирдлагын мэдээллийн систем

ҮБ – Үндсэн багш

ТББ – Төрийн бус байгууллага

ХААИС – Хөдөө Аж Ахуйн Их Сургууль

ХК – Хувьцаат компани

ХХК-Хязгаарлагдмал хариуцлагатай компани

## I. Магадлан шинжлэх үйл явц, төлөвлөлт

<b>Сургуулийн нэр /Монгол, Англи/</b>	ХААИС Агроэкологийн сургууль School of Agro-ecology, Mongolian University of Life Sciences	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</b>	Байгаль орчныг хамгаалах технологи	
<b>Индекс</b>	D071201	
<b>Шинжээчид</b>	<p>Ахлагчийн нэр, ажил, албан тушаал:</p> <p>1. Доктор, профессор Д.Нармандах- Монгол улсын Эрдэмийн их сургуулийн гадаад харилцаа, амтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал</p> <p>Гишүүдийн нэр, ажил, албан тушаал:</p> <p>2. Доктор, профессор Ж.Цэен-ойдов- МУШУТИС ЭХС-ийн дулааны инженерийн салбарын профессор</p> <p>3. Доктор Ю.Дэлгэрмаа – Газрын экологи компанийн захирал</p>	
<b>БМИУЗ-ийн зохицуулагч</b>	Зохицуулагчийн нэр, албан тушаал: Б.Мядагмаа- БМИУЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хариуцсан менежер	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b>
	2018.02.01- 2018.02.02	/Зохицуулагчийн гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/  Шинжээчийн багийн ажлын хуваарийн дагуу явагдсан.  Ажлын төлөвлөгөөг хавсралтаар оруулав.
<b>Шалгуур шаардлага /журам/</b>		

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

**Байгаль орчныг хамгаалах технологи хөтөлбөрийн үндэслэл.** Монгол орны нутаг дэвсгэрийн 70 гаруй хувь нь цөлжсөн, билчээрийн доройтол эрчимжсэн, байгалийн аюулт үзэгдлийн давтамж, эрчим сүүлийн 5 жилд олон жилийн дунджаас 3 дахин нэмэгдсэн, томоохон хот суурин газрын орчны бохирдол, стандарт хэмжээнээс давсан, уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын хэмжээ өссөн, амьтан, ургамлын тархац нутаг хумигдан, нөөц хомсдож байна.

Монгол улс 21-р зууны дэлхий нийтийн тогтвортой хөгжлийн бодлогод нийцүүлэн байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хөгжлийн тэнцлийг хангах замаар эдийн засгаа экологийн баримжаатай хөгжүүлэх, байгаль хамгаалах үндсийг бэхжүүлэхэд чиглэсэн ногоон хөгжилд суурилсан төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд байгалийн нөөц, баялагийн ашиглалт, хамгаалалтын өнөөгийн байдалд зөв шинжилгээ хийдэг, байгалийн нөөцүүдийн төлөв байдлыг тодорхойлох, хамгаалах, хяналт тавих, байгаль орчны

үнэлгээ, аудит хийх, менежментийг хэрэгжүүлэх мэргэжилтэй боловсон хүчин шаардлагатай байна.

**Байгаль орчныг хамгаалах технологи хөтөлбөрийн зорилго:** Энэхүү хөтөлбөр нь байгаль орчны суурь судалгаа хийх, аливаа төслөөс байгаль орчин, нийгэм, эдийн засагт нөлөөллөх нөлөөллийн үнэлгээ хийх, байгалийн нөөц, баялгийн ашиглалтыг экосистемийн даац, чадавхид тохируулан ашиглаж буй эсэхэд хяналт тавих, аудит хийх, тогтвортой ногоон хөгжлийг дэмжихэд чиглэгдсэн байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцүүдийн нөхөн сэргээлт хийхэд чиглэгдсэн оновчтой технологийг хэрэгжүүлэх, зөвлөмжлөх, менежмент хийх мэдлэг, ур чадварыг эзэмшсэн мэргэжилтэн бэлтгэх зорилготой.

БОХТ хөтөлбөрт

Байгаль орчны хяналт, үнэлгээ- 2006

Байгаль орчны нөхөн сэргээлт- 2012

Ургамлын нөөц био үйлдвэрлэл- 2003

Усны нөөцийн менежмент - 2017 гэсэн мэргэжлүүдээр мэргэжилтэн бэлтгэдэг.

“Байгаль орчныг хамгаалах технологи” хөтөлбөрөөр бэлтгэгдсэн мэргэжилтэн нь нийгмийн үйлдвэрлэлийн үйл явцтай холбоотой хүрээлэн буй орчинд гарч буй хувьсал өөрчлөлтийн эрчмийг тодорхойлж, өсөн нэмэгдэх аливаа эрэлт, хэрэгцээг хангах үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулж, тэдгээрээс байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг багасган, байгалийг хамгаалах оновчтой технологийг зөвлөмжлөх, хэрэгжүүлэх мэдлэг чадвар, дадал эзэмшиж байгаагаараа бусад хөтөлбөрөөс онцлогтой.

---

### III. Мэргэжлийн зөвлөлийн тодорхойлолт

/хавсралтаар оруулав/

### IV. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

#### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

#### 1.1 Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

#### Үзүүлэлт нотолгоо:

- **Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийсэн байдал:**
- Байгалийн нөөц баялгийн хомсдол, экологийн хямрал (1), байгалийн нөөцийн ашиглалт, хамгаалалтын байдалд тавих хяналт сул (2), байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилт сул (3), газар нутгийн эвдрэл, бохирдол ихээр гарсан (4), мэргэжилтний дутмаг байдал (5) гэх таван үндэслэлд тулгуурлан өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон байна.
- Монгол улсын байгаль орчны салбарт ажиллах мэргэжилтэн нь байгалийн нөөцийн ашиглалтын даац чадавхийг тооцоолох, нөхөн сэргээх технологийг эзэмшсэн байх шаардлагатай хэмээх шаардлагыг үндэслэн *Байгаль орчны*

*тэнцвэрт байдлыг хангах, Эдийн засгийн өсөлтийг хангах, Тогтвортой хөгжлийг хангах* хэмээх хэрэгцээнд тулгуурлан шаардлагыг тодорхойлсон байна.

- Хөтөлбөрийн эрэлт хэрэгцээний steer шинжилгээг хийж нийгэм, технологи, эдийн засаг, экологи, улс төрийн хэрэгцээт талбарууд дахь мэргэжлийн ач холбогдол, менежментийн утга санааг тодорхойлсон байна
- **Төгсөгчийн /мэргэжилтний/ загвар**
- Байгаль хамгаалах технологи хөтөлбөрийн төгсөгчийн чадварын ерөнхий загвар /2006-2012/, Төгсөгчийн мэргэжлийн ур чадварын загвар /2012-2017/-ыг тус тус схемчлэн гаргасан байна.
- Хөтөлбөрт оролцогч талуудтай удаа дараагийн уулзалт зохион байгуулж тэдний эрэлт хэрэгцээг тодорхойлон хөтөлбөрөөр төгсөгчийн мэдлэг ур чадварт үнэлгээ авч ажилласан байна.
- Ажлын байранд шаардагдах ур чадваруудад тулгуурлан хөтөлбөрөөр төгсөгчдийн ажиллах боломжтой ажлын байруудыг тодорхойлсон байна.
- **Хөтөлбөрийг индексийн хувьд ижил салбар, чиглэлийн гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан байдал /ялгаатай, давуу, сул тал, сайжруулалт/**
- НҮБ-ын гишүүн байгууллага ISCED-аас гаргасан ангилалаар ерөнхий чиглэлийн индекс 07 буюу инженерчлэл, үйлдвэрлэл ба инженерийн үйлдвэрлэл, нарийвчилсан чиглэл нь 0712 индекстэй “Байгаль орчныг хамгаалах технологи” гэсэн ангилалд хамаарна.
- БШУС-ын 2014,03.13 –ний өдрийн Мэргэжлийн чиглэлийн ерөнхий индекс 7 буюу инженерчлэл, инженерийн үйлдвэрлэл, нарийвчилсан чиглэл 0712 индекстэй хүрээлэн буй орчныг хамгаалах технологи, хөтөлбөрийн нэр байгаль хамгаалах технологи 071201 гэсэн ангилалд хамаарсан байна.
- Уг хөтөлбөрөөр Монголдоо анх удаа 2004 оноос мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн байна.
- Монгол улсад МУИС, ШУТИС, МУБИС, ХИС, МҮИС зэрэг сургуулиуд байгалийн нөөц ашиглалт, хамгаалалт гэсэн мэргэжлүүдээр мэргэжилтэн бэлтгэдэг байна.
- Дэлхий улс орнуудад уг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг 67 их сургууль байна. АНУ-ын Пурдугийн их сургууль, Вискансоны их сургууль, Мичиганы их сургууль, Стандфордын их сургууль Японы Китанюүшүгийн их сургууль, Канадын Ниаграгийн их сургууль, Жержийн их сургууль зэрэг сургуулиудын хөтөлбөрүүдтэй харьцуулан жишиж боловсруулсан байна.
- МУИС, ШУТИС, Байгаль орчин Эко Ази дээд сургууль, МҮИС–иудын мэргэжлийн сургалтын төлөвлөгөөний кредитийг (ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх суурь) харьцуулан судалсан байна. Эдгээр сургуулиудын төлөвлөгөөн дэх 28-33: 29-38: 25, уг хөтөлөрийнх 33: 29-38: 45 байна. МУИС-д ерөнхий суурь 30 уг хөтөлбөрт 33, мэргэшүүлэх хичээл МУИС 30 уг хөтөлбөрт 40-өөс илүү хувийн агуулгаар нөхөн сэргээлтийн технологийн хичээлүүд үздэгээрээ давуу талтай байна

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан /Хэсэгчлэн хангасан /Хангаагүй Онцлог зүйл /Туршлага:**

- Байгалийн нөөцийн ашиглалтын даац чадавхийг тооцоолох, нөхөн сэргээх технологи, байгаль орчны үнэлгээ хийх чадвар эзэмшсэн мэргэжилтэн бэлтгэхэд эрэлт хэрэгцээтэй анхны хөтөлбөр

**Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрөөр төгсөгчдийн ур чадварын загварыг ойлгомжтой, товч тодорхой тайлбарлаж оруулах

**Зөвлөмж:**

- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв байдлыг тодорхойлж, нарийвчилсан дүн шинжилгээ хийж, үүнтэй уялдуулан хөтөлбөрийг цаашид хэрэгжүүлэхдээ анхаарал хандуулах

## 1.2 Хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилго

Хөтөлбөрийн үзэл баримтлал тодорхой; төгсөгчийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлага нь мэргэжлийн салбарын хөгжил, зах зээлийн эрэлтэд нийцсэн байна.

### Үзүүлэлт нотолгоо:

- **Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримталж байгаа үзэл баримтлал, сургалтын арга зүй, тогтсон үнэлгээний систем**
- Монгол улсын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад байгалийн нөөц, баялгийг зөв зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхэд шаардлагатай мэдлэг, чадвар, дадлыг Сургалт-Эрдэм шинжилгээ-Үйлдвэрлэлийг хослуулсан системд хэрэгжүүлэхэд энэхүү хөтөлбөрийн үзэл баримтлал болно.
- Хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг, үр дүнд суурилсан сургалтын арга зүйг хэрэглэдэг байна.
- Хөтөлбөр нь мэргэжлийн мэдлэг чадвар, өргөн хүрээнд сэтгэх чадвар, академик суралцах чадвар, хувь хүний соёл төлөвшил, нийгмийн соёл төлөвшил гэх 5 чиглэлээр оюутныг чадамжтай болгоход чиглэгддэг байна. Эдгээр чадамжийг төлөвшүүлэхэд модулийн сургалт, интерактив сургалт, мультимедиа сургалт, E – сургалт, лекцийн хичээл, семинарын хичээл, лабораторийн хичээл, бие даах хичээл гэх сургалтын аргуудыг ашигладаг байна.
- Идэвхтэй сургалтын аргуудаас: кейсд суурилсан сургалт, асуудалд суурилсан сургалт, зориулагдсан орчинд суурилсан сургалт, туршилтад суурилсан сургалт, зохиол түүхэн явдалд суурилсан сургалтуудыг хэрэгжүүлж ирсэн байна.
- Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сургалтын уламжлалт болон орчин үеийн аргуудыг хэрэглэж ирсэн байна.
- Зарим туршлагатай багш тухалбал /Т.Оюунчимэг/ хичээлийн онцлогт тохируулж идэвхтэй сургалтын аргуудаас сонгон хэрэглэж байна. Байгал орчны эрх зүй хичээлээр харилцан идэвхтэй /Interactive/, мөн “Оюуны довтолгоо” арга, мөн зөрчлийг бүрэлдэхүүн хэсгүүдээр нь задлан бичих чадварыг сайжруулахын тулд Марафон бичлэг, Raft бичлэг, KWL болон Эссэ буюу чөлөөт бичлэгийн аргуудыг ашигладаг байна. Хуулийн гаргалгааг хийхдээ багаар ажилладаг тул ажлаа хамгаалахын тулд ярих чадварыг хөгжүүлж гол төлөв Мэтгэлцээний болон “Case Study” аргуудыг ашигладаг байна.
- 2003 оноос их сургуулийн хэмжээгээр “багшийн хөгжил хөтөлбөр”-ийг боловсруулан мөрдөж, уг хөтөлбөрт багш нарын мэргэжил, мэдлэг боловсрол, заах аргыг дээшлүүлэх дэс дараатай арга хэмжээг тусган хэрэгжүүлдэг байна.
- Оюуны үнэлгээний нэгдсэн систем (ОҮНС)-ээр оюутны мэдлэг чадварыг үнэлдэг байна.
- Суралцагчийг тасралтгүй хөгжүүлэхийн тулд Рубрикийн аргыг ашиглаж байна.
- Үнэлгээндээ 2016 оноос хойш ULMS.edu.mn програмыг ашиглаж байна.
- **Хөтөлбөрийн хүрэх үр дүн, онцлог, сургуулийн эрхэм зорилго, зорилттой нийцсэн байдал**
- ХААИС, Бүрэлдэхүүн сургуулийн эрхэм зорилго, зорилтуудад нийцүүлэн хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон байна.
- Хөтөлбөрийн үр дүнгийн /GAP/ шинжилгээг 2013 оноос өмнөх, 2014 оноос хойшхи байдлаар хийсэн байна.
- 2014 онд хийсэн сургуулийн бүтцийн өөрчлөлтийн хүрээнд мэргэжлийн хөтөлбөрийн зорилго, зорилтыг тэнхмийн багш нар эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн тодорхойлсон байна.
- **Төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход оролцогч, сонирхогч талуудын саналыг тусгаж, хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт төлөөллийг оролцуулсан байдал**

- Хөтөлбөрөөр төгсөгчийн мэдлэг, ур чадварыг өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангах түвшинд хүргэхийн тулд хөтөлбөрийг боловсронгуй болгоход хөтөлбөрийн хорооны гишүүд, ажил олгогчид, төгсөгчдийн төлөөллийг оролцуулан хөтөлбөрийн хорооны хурлыг 2015-2017 онд 8 удаа хийсэн саналыг хөтөлбөрт тусгасан байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан /Хэсэгчлэн хангасан /Хангаагүй**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөр нь мэргэжлийн мэдлэг чадвар, өргөн хүрээнд сэтгэх чадвар, академик суралцах чадвар, хувь хүний соёл төлөвшил, нийгмийн соёл төлөвшил гэх 5 чиглэлээр оюутныг чадамжтай болгоход чиглэгддэг байна.

### **1.3 Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга; сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй; сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тогтмол тусган сайжруулдаг байна.

**Үзүүлэлт нотолгоо:**

- **Хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангаж, баталгаажуулсан байдал**
- Монгол улсын БШУ-ны Сайдын 2014 оны А/78 тоот тушаал “Мэргэжлийн хөтөлбөр, чиглэл, индекс шинэчлэн батлах тухай”, БШУ-ны сайдын 2014 оны А/174 дүгээр тушаалаар батлагдсан “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”, БШУ-ны Сайдын 2014 оны А/285 дугаар тушаал, түүний хавсралт “Бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь чиглэлд заавал судлах хичээлийн жагсаалт”, ХААИС-ийн захирлын 2014 оны А/247 дугаар тушаалаар батлагдсан “ХААИС-ийн бакалаврын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө боловсруулах журам ”-ыг үндэслэн уг хөтөлбөрийг Агроэкологийн сургуулийн 2015 оны 06-р сарын 11-ний өдрийн А/192 тоот тушаалын хавсралтаар баталгаажуулж 2015 оны 09-р сарын 01-нээс эхлэн сургалт эрхэлж байна.
- **Сургалтын төлөвлөлт нь онол, практикийг зохистой хослуулсан, суралцагчийн мэргэжлийн болон хувь хүний ур чадваруудыг хөгжүүлэхэд чиглэсэн байдал**
- Сургалтын төлөвлөгөөг боловсруулан сайжруулахдаа онол практикийг хослуулах, хөтөлбөрөөр төгсөгчдийн мэргэжлийн болон хувь хүний ур чадваруудыг хөгжүүлэх чиглэлд анхаарч ажилладаг байна.
- Хөтөлбөрийг сайжруулахад: (а.) хөтөлбөрийн оролцогч талуудын санал, зөвлөмжийг тусгах, (б.) оюутны сэтгэл ханамжийн судалгааны үр дүн зэрэгт үндэслэн оюутны мэдлэг, ур чадвар, хандлагыг хөгжүүлэхэд чиглэсэн эрх зүйн болон агуулгын чанарын өөрлөлт хийх үзэл баримтлалыг гол чиг болгон ажилласан байна.
- **Хичээлийн хөтөлбөр нь хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, агуулга, ур чадварын хувьд харилцан залгамж холбоотой, сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт арга, хэлбэрийг тусгасан байдал**
- Хичээлийн хөтөлбөрийг 2010-2014 он, 2015 оны байдлыг харьцуулан жишиж үзсэн байна. Хичээлийн багтаамжийг нэмэгдүүлсэн байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан /Хэсэгчлэн хангасан /Хангаагүй**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Байгаль орчны суурь судалгаа хийх, аливаа төслөөс байгаль орчин, нийгэм, эдийн засагт нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ хийх, байгалийн нөөц, баялгийн ашиглалтыг экосистемийн даац, чадавхид тохируулан ашиглаж буй эсэхэд хяналт тавих, аудит хийх, тогтвортой ногоон хөгжлийг дэмжихэд чиглэгдсэн



байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцүүдийн нөхөн сэргээлт хийхэд чиглэгдсэн оновчтой технологийг хэрэгжүүлэх, зөвлөмжлөх, менежмент хийх мэдлэг, ур чадварыг эзэмшсэн мэргэжилтэн бэлтгэхэд чиглэгдэн Монгол улсын дээд боловсролын салбарт хэрэгжүүлсэн анхны хөтөлбөр болно.

#### **Анхаарах асуудал:**

Гадаадын их дээд сургуулиудын хөтөлбөрөөс авсан санаа, харьцуулалтыг тодорхой болгох

#### **Зөвлөмж:**

- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв байдлыг тодорхойлж, нарийвчилсан дүн шинжилгээ хийх
- Байгаль орчныг хамгаалах технологи хөтөлбөрийн төгсөгчийн чадварын ерөнхий загвар /2006-2012/, Төгсөгчийн мэргэжлийн ур чадварын загвар /2012-2017/-зэргийг тодорхой тайлбарлах

#### **1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Шалгуур 2. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл**

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн эсэхэд дүгнэлт хийх

##### **2.1 Сургалтын орчин**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- **Эрүүл, аюулгүй, тохилог орчинг бүрдүүлсэн байдал**
- Агроэкологийн сургууль нийт 55 өрөө тасалгаатай. Үүнээс багш нарын өрөө 20, лекцийн танхим 4, семинар дадлагын кабинет 11, лаборатори 17, бие даалтын танхим 2, эрдэмийн зөвлөлийн өрөө 1. Бүрэлдэхүүний сургуулийн хэмжээнд 2016 оны байдлаар 1 багшид ноогдох өрөө тасалгааны хангамж 5,2 м<sup>2</sup>, 1 оюутанд ноогдох хичээлийн танхим 0,72 м<sup>2</sup> байна.
- Хичээлийн байранд оюутны зоог, цайны газар, буфет, сүү сүүн бүтээгдэхүүний худалдаа үйлчилгээ, утасгүй интернетээр холбогдсон цахим банкны үйлчилгээ Хаан, Төрийн, Капитал банкны АТМ, 1500 оюутны хувцасны өлгүүр, оюутнуудад өөр өөртөө үйлчлэх хэвлэх машин байрлуулсан ба 400-600 хүний багтаамжтай театрын заалыг хурал, зөвөлгөөн семинар, кино үзвэрийн танхим хэлбэрээр ашигладаг.
- **Тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, лаборатори, урлангийн хангалт, ашиглалтын байдал**
- Багш бүр компьютер болон бусад дагалдах хэрэгслээр хангагдсан, багш нарын өрөө хичээлийн танхимууд интернетийн сүлжээтэй, ULMS программаар шинэчлэсэн. Багш нар цахим хэлбэрээр мэдээлэл авч солилцдог. Хичээлийн лекцийн 6 танхимд ТВ дэлгэц байрлуулж хичээлээ power point, аудио видео хэлбэрээр явуулдаг.
- Сургуулийн хэмжээнд 50-60 оюутныг нэг доор үйлчлүүлэх хүчин чадалтай интернет кафег 2014-2015 оны хичээлийн жилд байгуулсан.
- Оюутнууд захидал болон илгээмж явуулах цэгүүдээр үйлчлүүлдэг. 2011-2016 онд 5 лабораторийг шинэчлэж, 18 лабораторийг шинээр байгуулсан байна.
- Тус хөтөлбөр нь Баян-Чандманьд 1,5 га, Батсүмбэр Үдлэгийн аманд 2,0 га, Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд 2,0 га талбайд сургалт судалгаа

үйлдвэрлэлийн дадлага хийдэг.

- Ажилгүй байсан Дижитал студийг шинэчлэн БОХТ хөтөлбөрийн багш “Ногоон хөгжил” студи сургалтын студи байгуулан ажиллуулж байна.
- **Бие даан болон багаар ажиллах орчны хангалт**  
Агроэкологийн сургуулийн хэмжээнд оюутнуудын бие даалтын 3 өрөөг сургуулийн захирлын шийдвэрээр байгуулж тохижуулжээ. Хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд дадлагын 5 кредит цагийг 12 кредит цаг болгон нэмэгдүүлж оюутнуудын бие даан болон багаар ажиллах боломжийг нэмэгдүүлжээ.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан /Хэсэгчлэн хангасан /Хангаагүй**

#### **Онцлог зүйл/Туршлага**

- Ургамлын стресс, физиологийн лаборатори, Хөрс биохимийн лаборатори, Бэлчээр судалгааны лаборатори, Газар ашиглалат, төлөвлөлтийн лаборатори, Газрын үнэлгээ, мониторингийн лаборатори, Ландшафт, архитекторын лаборатори, Экологийн лаборатори зэрэг орчин үеийн шинжлэх ухаан технологийн хурдацад нийцсэн өндөр хүчин чадлын лабораториудыг 2011-2016 онд шинээр байгуулсан. Эдгээрийг байгууллагуудад гадаадын байгууллагуудаас 53,0 сая төгрөгийн дэмжлэг туслалцаа авсан байна.
- “Ногоон хөгжил” студи сургалтын студи байгуулан ажиллуулж байна.

#### **Зөвлөмж:**

Оюутны чөлөөт цагаар болон бие даалт хийх зэрэгт зориулан багаар ажиллах нөхцлийг бүрдүүлэхийн тулд коридорийн талбайг тохижуулан ашиглуулах талаар санаачлага гарган ажиллах

#### **2.2 Сургалтын хэрэглэгдэхүүн, хэрэгсэл**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- **Программ хангамж, симуляци, виртуал лабораторийн хэрэглээ, хүртээмж**
- Тус хөтөлбөрийн ангиудад нийт 5 лабораторийг сургалтанд ашиглаж 2015 онд шинээр 33 ш компьютер, 42 ширээ нэмэгдэж сурах орчин сайжирсан.
- Дээрх лабораторуудад БОХТ хөтөлбөрийн 15-20 оюутан 1 бүлэг болон хичээллэж байгаа бөгөөд программ хангамжийн хувьд боломжийн гэж үзжээ. Гэвч цаашид шинээр лаборатори нэмж байгуулах, багш нарыг хурд хүчтэй техник хэрэгслээр хангах шаардлагатай.
- **Хичээл практикийн материаллаг нөөц, хэвлэмэл үзүүлэн, тараах материал, хэрэглэгдэхүүний хүртээмж, хэрэглээ**
- Багш нар ихэвчлэн цаасан тараах материал, MNS стандарт, гербар үзүүлэн, хөрсний монолит байдлаар хичээл сургалтанд ашигладаг. Зарим хичээлд онлайн болон бичлэг хэлбэрээр илүү нарийн процессуудыг нарийвчлан харуулж байгаа.
- 2011 оныг 2015 онтой харьцуулахад лабораторын хичээлд зарцуулах мөнгөн дүн өссөн нь сургалтын хүртээмж сайжирсан гэж харагдаж байна.
- **Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмжийн хүртээмж**
- Үйлдвэрлэлийн дадлага хийж байгаа оюутан тус бүртэй гэрээ хийж дадлагын удирдамж болон заавар зөвлөмжөөр хангадаг.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан /Хэсэгчлэн хангасан/Хангаагүй**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Сургалтын үзүүлэн таниулах материалыг жил бүр шинэчлэн баяжуулдаг.
- Хөтөлбөрт оролцогч багш нар судалгааны ажлын үр дүнгийн олсон орлогоор анги танхимыг тохижуулдаг байна.
- Агроэкологийн сургуулийн хэмжээнд бүрэлдэхүүн сургуулийн захирлын шийдвэрээр оюунтууд бие даан ажиллах 2014, 2015 онд нэмж 3 өрөөг тохижуулсан байна.

### **2.3 Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт мэдээллээр тогтмол, чанартай хангадаг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- **Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн судалгаа, хүртээмж, хэрэглээ.**
- Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн гол нөхцөл болох ном сурах бичиг, арга зүйн материалаар хангах системтэй бодлого явуулж, жил бүр сургууль тэнхмийн ажлын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг үр дүнгийн гэрээ, өөрийн үнэлгээний тайлангийн биелэлтээр хянадаг.
- Тус сургуулийн номын санд уг хөтөлбөрийн боловсролын суурь хөтөлбөрт хэрэглэгддэг ном, сурах бичиг 4922 нэр төрлийн 20817 ширхэг, мэргэжлийн суурь хичээлд хэрэглэгддэг 1803 нэр төрлийн 7236 ширхэг, мэргэшүүлэх хичээлд хэрэглэгддэг 2436 төрлийн 8324 ширхэг ном, сурах бичиг, гарын авлага оюутнуудад үнэ төлбөргүй ашиглуулдаг.
- Тус хөтөлбөрөөр суралцагчид бакалаврын болон магистрын түвшинд англи хэл дээр 34 төрлийн 64 ширхэг, орос хэл дээр 23 төрлийн 146 ширхэг, монгол хэл дээр 38 төрлийн 238 ширхэг, нийт 448 ширхэг сурах бичиг ашигладаг.
- 2014-2015 онд шинээр авсан ном сурах бичгийн хангамж 66,4 % болсон байна.
- Байгаль орчныг хамгаалах технологи мэргэжлийн сургалтын төлөвлөгөөний дагуу шаардлагатай 500 гаруй нэр төрлийн 8000 гаруй ном сурах бичиг номын санд ашиглагдаж , нэг оюутанд 28,5 ном ноогдож байна.

#### **Виртуал, дижитал видео, аудио болон бусад цахим эх үүсвэрүүдийн байдал**

- Тус сургуулийн номын сангийн электрон каталогийн хаягаар орж багш, оюутнууд өөрт хэрэгцээтэй ном, сурах бичиг, хэвлэмэл материалуудыг номын нэр, зохиогч, түлхүүр үг гэсэн 3 үзүүлэлтээр хайх боломжтой.
- Магистр болон докторын бүтээлийн хураангуйн электрон файлыг ХАА-н төв номын сангийн эрдэм шинжилгээний фондод бүртгэж хадгалан нийтэд үйлчилдэг.
- Тус сургуулийн номын санд магистрын ажил хэвлэмэл 395 төрөл, CD 1162 төрөл, диссертаци 198 төрөл, Автореферат 1166 төрөл, бусад гарын авлага 900 гаруй төрөл байна.
- **Цахим орчны хүртээмж, хэрэглээ**
- Багш нар компьютер болон бусад дагалдах хэрэгслээр хангагдсан, багш нарын өрөө хичээлийн танхимууд интернетийн сүлжээтэй ULMS программаар шинэчлэгдсэн. Багш нар цахим хэлбэрээр мэдээлэл авч солилцдог. Хичээлийн лекцийн 6 танхимд ТВ дэлгэц байрлуулж хичээлээ power point аудио видео болгож ажиллуулдаг.
- Сургуулийн хэмжээнд 50-60 оюутанд нэг доор үйлчлэх хүчин чадалтай интернет кафег 2014-2015 оны хичээлийн жилд байгуулж ашиглаж байна.
- Тус сургуулийн 4 салбар номын сан, 10 фонд, 9 уншлагын танхимд цахим орчин бүрдүүлж ажиллаж байна.

- 2016 оноос сургуулийн нийт орчинд Wifi болон утастай интернет ашиглан мэдээ мэдээллийг олж авах боломжоор хангасан.
- Номын сангийн LIB4U программын 1, 9, 6 шинэчилсэн хувилбарыг үйлчилгээндээ нэвтрүүлж олон улсын нэр хүнд бүхий JSTOR, Oxford, Reference Online, BioOne, Organisation for Economic Cooperation and Development, Oxford medicine online цахим мэдээллийн санг ашигладаг.
- **Сургалт, судалгааны лицензтэй программын ашиглалтын байдал**
- Тус сургууль нь ULMS буюу University learning management system-ийг хэрэглэдэг бөгөөд уг программ нь оюутан тус сургуульд элсэхээс төгсөх хүртэл, төгссөний дараа ажилд орох явцыг удирдлагын мэдээллийн системээр хянахаас гадна тус сургуулийн санхүүгийн асуудал нийтэд нээлттэй болж улмаар гадаад, дотоодын магадлан итгэмжлэл, хөндлөнгийн үнэлгээнд гол шалгуур үзүүлэлтийг хангах нөхцөл бий болгож байгууллагын дотоод үйл ажиллагаанд мэдээллийн технологийг үр ашигтай ашиглаж орон зай, цаг хугацаанаас үл хамааран ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх нэгдсэн баазыг бий болгосон.
- 2014-2016 оны хичээлийн жилд ULMS 1.0 программыг Uniface /сургалтын алба/ программтай хослуулан үйл ажиллагаа явуулахаас гадна сургалтын албаны программ линк <http://muls.ulms.mn/>, багшийн программ линк <http://teacher.ulms.mn/>, оюутны программ линк <http://student.ulms.mn/> -ийг ашиглаж байна.
- Бүх ажилчдын компьютерийг жилийн хугацаатай Kaspersky вирусний лицензтэй программийг суулгаж өгдөг. Харин сургалт судалгаандаа лицензтэй программ төдийлөн ашиглаж чаддаггүй.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Сургалт, судалгааны лабораториудыг орчин үеийн дэвшилтэт шинэ тоног төхөөрөмжөөр тоногловсон
  - Ашиглагдахгүй байсан дижитал студийг шинэчлэн энэ хөтөлбөрийн хүрээнд “Ногоон хөгжил” сургалтын студи болгон байгуулж ашиглаж байна.
  - Хөтөлбөрийн бүх хичээлээр видео таницуулга хийсэн.

**Зөвлөмж:**

Оюутны чөлөөт цагаар болон бие даалт хийх зэрэгт зориулан багаар ажиллах нөхцлийг бүрдүүлэхийн тулд коридорийн талбайг тохижуулан ашиглуулах талаар санаачлага гарган ажиллах

**2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Шалгуур 3. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

#### **3.1 Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж,

нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

**Үзүүлэлт нотолгоо:**

- **Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдал**
- Тус сургууль нь 2006-2007 оны хичээлийн жилээс цахим их сургуульд зориулагдсан Стар Софт ХХК-ны бүтээсэн Uniface программ хангамжийг 3,0 хувилбараас нь эхэлж ашигласан. 2010-2011 оны хичээлийн жилд Uniface 4,0 программ хангамжийг сайжруулан Uniface 5,0 системийг хэрэглэж байна.
- **Хөтөлбөрийн нэгжийн /тэнхим, профессорын баг, хөтөлбөрийн хороо/ шийдвэр гаргалт, хэрэгжилтийн үнэлгээнд багш, суралцагчдын оролцоог нээлттэй, ил тод хангасан байдал**
- Сургуулийн захирлын 2015 оны А/192 тушаалаар БОХТ хөтөлбөрийн хороог байгуулсан ба хөтөлбөрийн чанарыг оролцогч талуудын сэтгэл ханамжийн үнэлгээ, санал хүсэлтийг тусган хянаж ажилладаг. /багш, төгсөгч, ажил олгогч, оюутан/
- **Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай дүрэм, журмуудын хэрэгжилт**
- БОХТ хөтөлбөрийн баг БСШУ сайдын 2014 оны А/78 тоот тушаалаар Мэргэжлийн /хөтөлбөр/ чиглэл, индекс шинэчлэн батлах тухай, 2014 оны А/174 тоот тушаалаар Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага, 2014 оны А/285 тоот тушаалаар Бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь чиглэлд заавал судлах хичээлийн жагсаалт, 2014 оны А/285 тоот тушаалаар Бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь чиглэлд заавал судлах хичээлийн жагсаалт,
- ХААИС –ийн захирлын 2014 оны А/427 тоот тушаалаар батлагдсан Бакалаврын хөтөлбөрийн, сургалтын төлөвлөгөө боловсруулах журам, 2014 оны А/228 тоот тушаалаар батлагдсан Хөтөлбөрийн хорооны журам, Сургалтын бодлого зохицуулалтын албанаас гаргасан ХААИС-ийн бакалаврын сургалтын хөтөлбөрийн загвар, 2014 оны А/202 тоот тушаалаар Бүрэлдэхүүн сургуулийн тэнхим, хөтөлбөр батлах тухай, 2014 оны А/427 тоот тушаалаар ХААИС-ийн бакалаврын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө боловсруулах журам зэрэг эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа мөрдөж хэрэгжилтийг хангаж ажилладаг.
- **Урт болон богино хугацааны төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлан, ахиц өөрчлөлтийн дүн шинжилгээ механизм**
- ХААИС 2010 оноос ХААН КАМПУС хөтөлбөр хэрэгжүүлж 2011-2020 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулан эрхэм зорилгоо амьдралын ухаан, хосолсон бүс нутгийн манлайлах их сургууль болно гэж тодорхойлж:
  1. Сургуулийн менежментийг боловсронгуй болгох
  2. Шинжлэх ухаан мэдээлэл, технологийн чадварыг нэмэгдүүлэх
  3. Сургалтын агуулга, технологи, стандартыг төгөлдөржүүлэх
  4. Оюутан суралцагсдад үзүүлэх үйлчилгээг хөгжүүлэх
  5. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх
  6. Сургалт, судалгааны орчин, нөөцийг өргөжүүлэх зэрэг зорилтуудыг тавьж хэрэгжилтийг хангуулж байгаа.
- БОХТ хөтөлбөр нь 2017-2018 оны хичээлийн жилээс эхлэн БОХТ хөтөлбөрийн стратеги төлөвлөгөө боловсруулан ажиллаж байгаа.
- Тус сургуулийн багш нар үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр гарган биелэлтийг нь өөрийн үнэлгээний тайлан хэлбэрээр тайлагнадаг.
- ХААИС 2015 оноос өмнө улирлын системээр сургалт явуулдаг байсан бөгөөд 2015-2016 оны хичээлийн жилээс эхлэн богиносгосон улирлын Периодын системээр сургалт явагдах болсноор зарим ахиц дэвшилүүд гарсан. Тухайлбал оюутнууд цөөхөн хичээл богино хугацаанд шахуу үзэж хичээлд төвлөрөх байдал, сурах сонирхол нэмэгдсэн, багш нарт судалгаа шинжилгээний ажилд цаг гарч ажлын үр дүн нэмэгдэж, багш нарын

бүтээл туурвил гарын авлага, судалгаа шинжилгээний ажлын тоо, чанарт ахиц гарсан гэж үзсэн.

- 2017 он хүртэлх хугацаанд хөтөлбөрийн урт хугацааны төлөвлөлтийг ХААИС-ийн стратеги төлөвлөлт болон бусад бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан хийж ирсэнээс гадна шинээр анги нээх үндэслэл, тэдгээр мэргэжлийн онцлог, эзэмших ур чадварыг зах зээлийн эрэлт, нийлүүлэлтэд тулгуурлан өөрчлөлт хийж иржээ.

- **Санал, гомдол хүлээн авах, хариу өгөх үйл ажиллагаа, систем бүрдсэн байна.**

- Сургуулийн хэмжээнд суралцагчдын гомдол, саналыг сургалтын албаны дэргэд санал хүсэлтийн хайрцаг ажиллуулж, мэдээллийг багш нартай солилцож холбогдох арга хэмжээг авч ажилладаг.

- Тэнхмийн эрхлэгч тэнхмийн оюутны санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэж ажилдаг.

- **Хөтөлбөрийн багш, ажилтнуудын хүний нөөцийн судалгаа, шинжилгээ, хөгжүүлэх ажлын үнэлгээ, гүйцэтгэлийн болон үр дүнгийн урамшууллын хэрэгжилт**

- Тус хөтөлбөрт хичээл заадаг профессор багш нарын тоо 2011 онд 22 байснаа 2015 онд 29 болж нэмэгдсэн, мэргэжлийн хөтөлбөрийн багш нарын албан тушаалын зэрэглэлд гарсан өөрчлөлтийг авч үзвэл 2011-2012 онд 9, 2015-2016 онд 15 болж өөрчлөгдсөн.

- Бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд жил бүр мэргэжлийн багш нарыг оны шилдэг Залуу багш, Судлаач багш, Сурган хүмүүжүүлэгч багш гэсэн номинацаар шалгаруулан өргөмжлөл мөнгөн шагналаар урамшуулдаг.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй**

**Онцлог зүйл/Туршлага:**

• Хичээл нэг бүрийг судалж дууссаны дараа дүн гарахаас өмнө хөтөлбөр оролцогч тал буюу оюутнуудаас оюутны сэтгэл ханамжийн судалгааг онлайнаар авдаг болсон нь хөтөлбөрийг цаашид сайжруулах удирдан зохион байгуулахад тус дөхөм болж байна.

### **3.2 Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

**Үзүүлэлт нотолгоо:**

- **Хөдөлмөрийн зах зээлийн тандан судалгааны давтамж**
- Монгол улсад байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 9 их, дээд сургууль байх боловч байгаль орчныг хамгаалах технологи хөтөлбөрийг анх ХААИС хэрэгжүүлсэн.
- Уг хөтөлбөр нь нийгмийн эрэлт хэрэгцээнд суурилсан тул элсэгчдийн тоо тогтвортой нэмэгдэж байгаа.
- **Хөтөлбөрийн сурталчилгаа, идэвхжүүлэлтийн арга хэлбэр, хүртээмж, үр нөлөө**
- Хөтөлбөрийн сурталчилгааг “ХААИС-ийн маркетингийн идэвхжүүлэлтийн хөтөлбөр” /2015-2017/ -ийн хүрээнд явуулдаг. ЕБС-ийн сурагчдад мэргэжил сурталчлах уулзалт, өдөрлөг зохион байгуулах, сургуулийн сургалтын үйл ажиллагаатай танилцуулах, Мэргэжил бүхэн сайхан өдөрлөг зохион байгуулах, сурагчдад мэргэжил сурталчлах уулзалтыг жил бүр хийж хөтөлбөрийн танилцуулга, суралцах эрхийн бичиг гардуулах хэлбэрээр идэвхижүүлдэг.
- Хөтөлбөрийн танилцуулгыг онлайнаар олон нийтэд танилцуулга хийж, байршуулсан.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан /Хэсэгчлэн хангасан/Хангаагүй**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн болон хичээл нэг бүрийн танилцуулгыг хийж онлайнаар олон нийтэд танилцуулан, цахим орчинд байршуулсан нь сийан туршлага болж байна..

### **3.3 Төгсөлтийн дараах бодлого**

Хөтөлбөр нь төгсөгчидтэйгээ байнгын эргэх холбоотой, тэдний мэргэжлийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулж, төгсөгчид нь суралцаж буй суралцагчдад мэргэжлийн чиглэлээр ажиллахад нь зөвлөн тусладаг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

##### **- Төгсөгчдийн карьерын өсөлтийн судалгаа**

-Төгсөгчдийг амьдралын ухаан, байгаль орчны тэргүүлэх чиглэлээр ШУ- сургалт-үйлдвэрлэл- бизнесийг хосолсон манлайлагч их сургууль болох зорилтын хүрээнд тэдний мэдлэг ур чадварыг дээшлүүлэхээр ахисан түвшний сургалт буюу магистр докторын сургалтын хөтөлбөрийг бие даасан бүтэцтэйгээр байгуулж, төгсөгчдийг үргэлжлүүлэн сурах оломжоор хангасан.

- Төгсөгчдийн карьерын судалгааг хийж эхэлж байгаа.

##### **- Үргэлжлүүлэн суралцагчдын хувь хэмжээ**

- Уг хөтөлбөрт суралцан төгсөгчдийн 20 орчим хувь нь сургуульдаа ахисан шатны сургалтанд хамрагдсан. Тухайлбал 2009-2017 онд нийт 102 төгсөгч магистрт элсэн орж суралцаад тэдгээрээс 70 суралцагч магистрын зэргийг амжилттай хамгаалсан байна. Одоогийн байдлаар магистрт 49, докторт 5 суралцагч суралцаж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд магистр, докторт элсэгчдийн тоо өсөх хандлагатай байгаа нь төгсөгчдийг давтан сургалтанд хамруулах бодлогыг хэрэгжүүлсэний үр дүн гэж үзсэн.

##### **- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах бодлого, төлөвлөгөө, хамрагдсан байдал**

-Уг хөтөлбөр нь төгсөгчдөө чадвахжуулах зорилгоор богино хугацааны 2,5 кредитийн багтаамжтай сургалт зохион байгуулдаг. Жишээлбэл 2017 оны сургалтанд 78 суралцагчаас байгаль орчныг хамгаалах технологи хөтөлбөрийн 25 төгсөгч хамрагдсан байна.

##### **- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны тогтмолжсон байдал**

- Төгсөгчдийн холбоог байгуулах шатанд явж байгаа.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багш нар оюутан, төгсөгчдийн харилцаа холбоо, хамтын ажиллагаа нягт байгаа нь ажиглагдлаа.

#### **Анхаарах асуудал:**

- Төгсөгчдийн карьерын өсөлтийн судалгааг боловсронгуй болгох.

#### **Зөвлөмж:**

- Төгсөгчдийн холбоог байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах.

### **3.4 Олон улсын харилцаа, хамтын ажиллагаа**

Олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- **Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн тайлан, дүгнэлт**
- Уг хөтөлбөрийн хүрээнд 10 гаруй орны 20 гаруй их сургууль эрдэм шинжилгээний байгууллагууд 30 гаруй оюутан, 20 гаруй багш сурган хүмүүжүүлэгч эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, сургалт судалгааны багт хамрагдсан байна.

- Олон улсын хэмжээнд хамтран хэрэгжсэн төсөл 2015 оны байдлаар 2 болж олон улсын хамтын ажиллагааны хүрээ нэмэгдсэн.
- **Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоо**
- Сургалтын чанарыг сайжруулах хүрээнд багш, оюутан арга туршлага солилцох ажлыг тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлж цаашдаа өргөжүүлэхээр төлөвлөж байна.Тухайлбал: Японы цас их унадаг бүс нутгийн ойн аж ахуй ба хөдөө аж ахуй сэдэвт 14 хоногийн сургалтанд 2015 онд 10 оюутан, 2016 онд Япон улсын Яматагийн их сургуульд 1 оюутан хамруулсан. 2015 онд ХААИС болон Yamagata University, Japan, Leibniz Universitat Hannover, Germany, University of Lleida, Spain, Хятадын Хейлонгжаны Их сургуулийн нийт 52 оюутан 6 багш хамтарсан сургалт зохион байгуулжээ. 2016 оны 11 сард тус хөтөлбөрийн багш С. Бүрэнжаргал, Т. Байгал-Амар нар Австрийн Венийн их сургуульд профессороор ажиллахаар болсон.
- 2011 оныг 2015 онтой харьцуулахад Олон улсын их дээд сургууль, эрдэм шинжилгээ судалгааны байгууллагатай багш, оюутан солилцож тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоо 8 дахин нэмэгдсэн.
- **Олон улсын хурал семинар, судалгаа болон бусад арга хэмжээнд оролцсон тоо, үр дүн, ач холбогдол**
- Хөтөлбөрийн хүрээнд 10 гаруй орны 20 гаруй их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 30 гаруй оюутан, 20 гаруй багш эрдэмтэн шинжилгээний хурал, зөвлөгөөн, сургалт судалгаанд хамрагдаад байна.
- Олон улсын хурал семинарт оролцогсдын тоо 2010 оныг 2015 онтой харьцуулахад 5-6 дахин өсчээ. Тухайлбал: 2015 онд Understanding environmental and socio-economic changes in Mongolia сэдэвт олон улсын хуралд 10 оюутан 4 багш оролцсон байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй**

**Зөвлөмж:**

- Олон улсын хамтарсан баталгаат хөтөлбөрүүдийг тодорхой болгох

### **3.5 Дотоод хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нь мэргэжлийн холбоод, үйлдвэр, үйлчилгээний байгууллагууд, ажил олгогч эздийн холбоо, төрийн болон ТББ-уудтай хамтран ажилладаг байна.

**Үзүүлэлт нотолгоо:**

**- Хамтран ажиллах гэрээ, хэлцэл, ажлын үр дүн**

- Тус хөтөлбөр нь 4 чиглэлийн 29 аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллаж байна. Үүнд: мэргэжлийн холбоод 3, үйлдвэр үйлчилгээний байгууллага 4, төрийн байгууллага 13, төрийн бус байгууллага 3.
- Түүнчлэн үйлдвэрлэлийн дадлагыг үйлвэрлэлийн танилцах дадлага, орон нутгийн дадлага гэсэн 2 үе шаттайгаар явуулж танилцах дадлагыг жил бүр 7-11 үйлдвэр, аж ахуйн нэгжийн технологийн дамжлага, байгаль орчны менежменттэй танилцдаг. Үйлдвэрийн технологи, байгаль орчны менежменттэй танилцах дадлагыг хичээлийн жилийн төгсгөлд 5-7 сард 2-3 багш удирддаг.
- **Хэрэгжүүлж буй ажлуудын тайлан, дүгнэлт**
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нь 2011-2016 онд 4 чиглэлийн 29 аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ажиллаж , Бакалавр, магистр оюутнууд судалгааны ажлаа гүйцэтгэж практик дээр ажил гүйцэтгэх дадал эзэмшдэг
- Багш нар мэргэжлээ сурталчилах, зөвлөгөө өгөх зэргээр нийгэмд мэргэжлийн үйлчилгээ үзүүлж, мэргэжлийн хэлэлцүүлэг сургалт семинар зохион байгуулж, судалгааны ажил гүйцэтгэж, үр дүнгээр нь гарын авлага хэвлүүлж хөтөлбөрийн



- эрдэм шинжилгээний материаллаг баазад хувь нэмрээ оруулж ажилласан байна.
- Хамтын ажиллагаатай аж ахуйн нэгж, байгууллагын тоо жилээс жилд өсөж байгаа нь дээр дурьдсан сургалт, судалгаа, материаллаг баазын хувьд хөтөлбөрт эерэгээр нөлөөлж байна гэж үзсэн.
  - **Хамтын ажиллагааны арга, туршлага**
  - *Мэргэжлийн холбоотой хамтран ажилласан арга туршлага:*
  - БОНБҮ Эрхлэгчдийн холбоотой хамтран ажиллаж сүүлийн 5 жилийн хугацаанд нийт 30 төслийн БОНБНҮ хийсэн байна.
  - Залуу эрдэмтдийн холбоотой хамтран Хүрэл тогоот 2015, Хүрэл Тогоот 2016 эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж, багш нарын судалгааны үр дүнг олон нийтэд таниулах, хэвлүүлэх зэргээр эрдэм шинжилгээний ажилд тодорхой хувь нэмэр оруулж байна.
  - Мэргэшсэн ойчдын холбоотой хамтын ажилгааны хүрээнд зохиогдож байгаа хурал, семинарт оролцож, суралцагчдыг хамруулах зэргээр хамтран ажиллаж байна.
  - **Үйлдвэр үйлчилгээний байгууллагатай хамтран ажилласан арга туршлага:**
  - ЭКО ТВ, МҮОНТ-тэй хамтран ажиллаж, Ногоон эдийн засаг-экофорум, Ногоон хөгжил зэрэг нэвтрүүлгүүдийг олон нийтэд хүргэсэн.
  - Нутаг түншлэх ХХК хамтран Өмнөговь аймгийн Ханбогд сумын ургамалжилтын ажиллагаа, Оюу толгой ХК-ийн захиалгаар хөрсний экологи, эдийн засгийн анхдагч суурь үнэлгээ тогтоох судалгааны ажлуудыг тус тус гүйцэтгэсэн байна.
  - Балхэ-Монгол ХХК-тай эмийн ургамлын талбайд ажиллах, танилцах дадлага хийх зэргээр хамтран ажилласан байна.
    - **Төрийн байгууллагатай хамтран ажилсан арга туршлага**
  - ШУА-ын Геоэкологийн хүрээлэнгийн Дамбадаржаагийн мод үржүүлгийн газар жил бүр мод сөөг тарих ажилд Байгаль Орчны нөхөн сэргээлтийн ангийн оюутнуудыг хамруулан ажиллаж байна.
  - Цэнгэг усны нөөц, Байгаль хамгаалах төв, МУИС-ийн Экологийн боловсрол олгох төв, БЗД-ын Тамгын газар, Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын захиргаа, Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газар зэрэг байгууллагуудтай сургалт, судалгааны ажлын хүрээнд хамтран ажиллаж байна.
  - ШУА-ын Геоэкологийн хүрээлэн, БОНХАЖЯ-ны харьяа Бортогоны үйлдвэр, Нийслэлийн агаарын чанарын алба, Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл зэрэг байгууллагын үйл ажиллагааг оюутанд таниулах, дадлага туршлага олгох зорилгоор сургалтын ажлын хүрээнд хамтран ажиллаж байна.
  - **Төрийн бус байгууллагатай хамтран ажилласан арга, туршлага:**
  - Ногоон санаачлага холбоо, Экологи шинэ мандал ТББ, Экологи технологи, хөгжил ТББ зэрэг байгууллагуудтай сургалт судалгааны ажлаар хамтран ажиллаж, гарын авлага хэвлүүлэх зэргээр сургалтын материаллаг баазыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулсан байна.
  - **Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо үр дүн /багш, суралцагчдын зүгээс/**
  - Тус хөтөлбөрийн багш бүр мэргэжлийн холбоод, үйлдвэр үйлчилгээний байгууллагууд, ажил олгогч эздийн холбоо, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр хамрагдагсдын тоо, үр дүнг багш тус бүрээр гаргаж нэгтгэн үзүүлсэн бөгөөд энэ нь давуу тал болж байна.

- Байгаль орчны хяналт үнэлгээ мэргэжлийн ангид мэргэшүүлэх хичээл заадаг, профессор багш нар аж ахуй нэгж, байгууллагын байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийдэг, БОНБУ эрхлэгчдийн холбоотой хамтран ажиллаж байгаа хөтөлбөрийн үйлчилгээний давуу тал болж байна.
- Байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн холбоо, бусад байгууллагатай багш нар хамтран ажиллаж, үйл ажиллагаандаа бакалавр, магистр оюутнуудыг хамруулан ажиллаж байна. Хамтын ажиллагааны хүрээнд оюутан судалгааны ажил хийх, онолын мэдлэгээ практикт бататгах өргөн боломж бүрдүүлж байна.
- Үйлдвэрлэлийн дадлагаар манай улсын томоохон үйлдвэрийн бүсүүдэд үндэсний шилдэг үйлдвэрийн технологи, байгаль орчны менежменттэй танилцаж байгаа нь хөтөлбөрийн давуу тал болно.
- Ажил олгогч эздийн холбоо болон бусад ажил олгогчид, төр хувийн хэвшилтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх, шаардлагатай байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй**

**Зөвлөмж:**

- ХАА-н салбарын холбогдох мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах
- Хамтын ажиллагааг улам бүр үр дүнтэй бодит болгож сайжруулах үүднээс хамтын ажиллагааны албан ёсны гэрээ, хэлэлцээрийг хийж байх

### **3.6 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

**Үзүүлэлт нотолгоо:**

- **Төсөв, санхүүгийн бие даасан байдлын хөгжил**
- БОХТ хөтөлбөрийн санхүүгийн ашиг, алдагдлын судалгааг 2011-2016 хүртэлх 5 хичээлийн жилээр хийсэн. Тухайлбал хөтөлбөрөөс орох орлого 2011-2012 оны хичээлийн жилд 15, 2015-2016 оны хичээлийн жилд 10 сая байна.
- **Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо**
- ХААН КАМПУС хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн үйлчилгээ дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байгаа юм байна.
- 1 оюутанд ноогдох зардал 2010-2011 оны хичээлийн жилийг 2015-2016 онтой харьцуулахад 1 оюутанд ноогдох зардал 756,964 төг. байснаа 1,578,958 төг болж өсөж ирсэн байна.
- Сургалтын төлбөрийг курсээс хамааруулан ялгаатайгаар уян хатан ялгаатай тогтоож иржээ.
- Хичээлийн жилд оюутанд үзүүлэх үйлчилгээний зардлыг /сургалтын болон үйлдвэрлэлийн дадлага гэх мэт/ тэнхмийн зүгээс сургуулийн төсөвт санал болгож тусгуулдаг.
- ХААИС дотоод журмын хүрээнд оюутанд хөнгөлөлт үзүүлэх журам нь улирлын үнэлгээний голч дүн 3,7-с их амжилт үзүүлсэн оюутнуудыг Ректорын нэрэмжит хуудсанд бичиж 3 удаа хуудсанд бичигдсэн зөрчил гаргаагүй тохиолдолд сургалтын төлбөрийн 20 %-ийг хөнгөлдөг.
- **Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв**
- Экологийн тэнхимийн сүүлийн 5 жилийн батлагдсан төсвийг нийт зардлын дүнгээр авч үзэхэд тасралтгүй өссөн дүнтэй гарч байна.

- Сургалтын орчныг сайжруулах талаар 2012-2013 оны хичээлийн жилд урсгал ба их засварын ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.
- Хичээлийн байрны коридор, хичээлийн болон багш нарын өрөөнүүдэд жил бүр урсгал засвар хийж хичээлийн өрөө танхим, коридорын гэрэлтүүлэг, цахилгааны монтажийг шинэчилж, ханын будаг, хаалга зэргийг орчин үеийн нөхцөл шаардлагад нийцүүлэн засварлаж сургуулийн өмнөх талбайг цементээр хучиж, нийтийн бие засах газруудыг шинэчлэн тохижуулсан.
- Хамт олны саналыг авч сургуулийн төсөвт сургалтын орчны материаллаг бааз, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, анги танхимын тохижилтын зардлыг тусгаж санхүүжилт хийдэг.
- **Төр хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалт**
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад экологийн тэнхимийн багш нар шинжлэх ухааны болон суурь судалгааны төсөл хэрэгжүүлэх захиалгат болон гэрээт ажлыг гүйцэтгэх, мэргэжлийн сургалт зохион байгуулах болон бусад үйл ажилгаагаараа орлого хандивыг сургуульд болон тэнхимд төвлөрүүлдэг.
- Түүнчлэн судалгааны ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлж тодорхой хэмжээний орлогын эх үүсгэвэр бий болгож ажилладаг.
- Сүүлийн жилүүдэд эрдэмтэн доктор багш нарын эзлэх хувийн жин нэмэгдсэнтэй холбоотой хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын төсөл судалгаа гэрээт ажил, гүйцэтгэх хувь, цар хүрээ нэмэгдэх хандлагатай гэж үзжээ.
- **Төсвийн уламжлалт бус эх үүсвэр, бүрдүүлэлт, хуваарилалт, санхүүжилт**
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар судалгаа шинжилгээний ажлын санхүүжилт болон бусад үйл ажиллагааны үр дүнгээс бэлэн мөнгөөр болон ном, сурах бичиг, бусад сургалтын материалын хандивыг тэнхим, сургуульдаа өгдөг.
- Тэнхимийн эрдэмтэн багш нарын тоо нэмэгдэж, үйл ажиллагааны цар хүрээ тэлсэнтэй холбоотой төсөл хөтөлбөр, гэрээт ажлууд нэмэгдэх хэрээр тодорхой хэмжээний санхүүжилт олох болсон байна.
- Оюутанд үзүүлэх үйлчилгээний зардлыг сургуулийн төсөвт тусгаж оюутнуудын дунд зохиогдох эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг, спорт урлагийн бусад арга хэмжээний зардлыг жил бүр төсөвлөн тэнхим болон оюутны холбоогоор дамжуулан санхүүжилт авдаг.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- ХААИС-ийн ногоон байгууламж төсөлд БОХТ хөтөлбөрийн хүрээнд сургуулиас 3-9 сая төгрөгийн санхүүжилт өгдөг. 2007 оноос жил бүр 10 оюутныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр 3 сар цалинжуулж сургалтын төлбөрт нь дэмжлэг болгодог.
- Агрономийн багш жил бүр 2000 м<sup>2</sup> талбайг зүлэгжүүлэх ажлыг хийдэг, зах зээлийн ханшаар 20-30 сая төгрөг болж байна.
- Хөтөлбөрийн багш нар өөрсдийн санаачлагаар ном сурах бичгийг номын санд хандивлан сургалтанд ашигладаг.

#### **Анхаарах асуудал:**

- Төр, хувийн хэвшлийн байгууллагаас үзүүлэж буй санхүүгийн дэмжлэг, түүний зарцуулалтыг нарийвчлан гаргаж байхад цаашид анхаарах

### **Зөвлөмж:**

- Өөрсдийн судалгааны ажлын орлогоор хөтөлбөрийн сургалтын орчныг сайжруулах талаар санаачлан хийсэн зүйлийг албажуулж бүртгэлжүүлэн урамшуулахад анхаарах

### **3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Шалгуур 4. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа**

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

#### **4.1 Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- **Суралцагч элсүүлэх эрх зүйн зохицуулалтад хөтөлбөрийн онцлогт нийцсэн шалгуурыг тусгасан байдал**
- ХААИС-ийн элсэлтийн журмын дагуу оюутан элсүүлэх ХААИС-ийн захирлын тушаалаар элсэгчийг хүлээн авдаг байна. Оюутны элсэлт, сургалтын нөхцөл, оюутан элсүүлэх хөтөлбөр, мэргэжлийн чиглэл, элсэлтийн бүртгэл, элсэлтийн хөнгөлөлттэй нөхцөл, элсүүлэх журамтай бөгөөд тэдгээрийг [www.muls.edu.mn](http://www.muls.edu.mn), [www.elselt.muls.edu.mn](http://www.elselt.muls.edu.mn) линкүүдээр үзэх боломжтой юм.
- 2015 оноос эхлэн мэргэжилдээ дур сонирхолтой төгсөөд мэргэжлээрээ ажиллах сонирхолтой элсэгчдийг элсүүлэх бодлого баримтлан ажиллаж байна. ЕБС-ийн сурагчдад мэргэжлээ таниулах зорилгоор **“Мэргэжил миний ирээдүй”** хөтөлбөр, элсэлтийн нээлттэй мэдээлэл Мишээл Экспо-д зохион байгуулагддаг олон улсын үзэсгэлэн яармаг, МИДСК-ын гишүүн их дээд сургуулиудыг таниулах зорилготой **“Оюутны хавар”** боловсролын үзэсгэлэн яармаг, эрлэмтдийн бүтээл, мэргэжлийн онцлогийг таниулах зорилготой **“ХААИС-ийн элч оюутан”** хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг байна.
- **Элсэгчдийн ЕШ-ийн дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа**
- Төрийн захиргааны байгууллагын захиалга, зах зээлийн эрэлт, хэрэгцээ, сургуулийн материаллаг бааз, багшлах бүрэлдхүүний хангамж зэргийг харгалзан БСШУЯ-наас баталсан элсэгчдийн хяналтын тоонд багтаан оюутан элсүүлдэг байна. Тухайлбал, хяналтын тоо 200 бол 2014-2015 оны хичээлийн жилд-128, 2015-2016 оны хичээлийн жилд -83, 2016-2017 оны хичээлийн жилд-88 оюутан элсүүлсэн байна.
- Элсэгчдийн ЭЕШ –ийн дундаж оноо, дээд онооны талаарх сүүлийн 3 жилийн судалгааг гаргасан байна. Дээрх хугацаанд дундаж оноо – 482, 493.1, 488.4; дээд оноо – 631, 665, 592 болсон байна.
- **Шинээр элссэн суралцагчдыг чиглүүлэх сургалтад хамруулж, мэдээлэл, гарын авлагаар хангасан байдал**
- Шинээр элсэгчдэд **“Оюутны гарын авлага”**- ыг сургуулийн сургалтын алба, зөвлөх багшийн оролцоотойгоор олгож, хэрэглэх зааврыг зөвлөх багш оюутан бүрт тайлбарлаж өгдөг байна. Оюутны гарын авлагад ХААИС-ийн захирлын мэндчилгээ, ХААИС-ийн түүхэн замнал, бүтэц, ХААИС-ийн оюутны тангараг, мэргэжлийн хөтөлбөрийн танилцуулга, оюутны мөрдөх дүрэм, журам, оюутны ёс зүйн дүрэм, номын сангийн үйлчилгээ, мэдээллийн сан, уншлагын танхимууд, оюутны дотуур байрны журам, сургалтын үйл ажиллагааны мэдээллийг багтаасан байна.

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

### Онцлог зүйл/Туршлага:

- Элсэгчид мэргэжил сонгоход хөтөлбөрийн танилцуулгыг сургуулийн ВЭБ сайтанд байрлуулсан байна.
- Элсэгчдэд зориулсан мэргэжлийн сурталчилгааг олон нийтийн сүлжээ, сургуулийн цахим хаяг, элсэлтийн цахим хаяг, өдөр тутмын сонин, телевизийн хөтөлбөрүүд, хэвлэлүүд, “Мэргэжил миний ирээдүй”, “ХААИС-ийн элч оюутан” г.м. хөтөлбөр, “Оюутны хавар” боловсролын үзэсгэлэн яармаг, төсөл хөтөлбөрүүд, “Оюутны гарын авлага” зэрэг олон хэлбэрүүдээр хийдэг байна.

### 4.2 Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчдад суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогмол, чанартай үзүүлдэг байна.

### Үзүүлэлт нотолгоо:

- **Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, график, үр дүн**
- Их сургуулийн хэмжээнд 24 профессорын баг, 20 гаруй сургалт, судалгааны лаборатори байгуулагдаж эрдмийн зэрэгтэй багшийн тоо 50 гаруй хувьд хүрсэн байгаа нь эрдэм шинжилгээ судалгааны ажлын чадавхи эрчимтэй нэмэгдэж, зөвлөх үйлчилгээний суурь бааз бий болсныг илтгэж байна.
- ХААИС-ийн багш судлаачид нь өөрчлөгдөн хувьсч буй орчин, шинжлэх ухаан технологийн хөгжилтэй мөр зэрэгцэн өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх үүрэг хүлээдэг бөгөөд тэдний өөрийгөө хөгжүүлэх боломжийг бүрдүүлэхэд сургуулийн захиргаа анхаарал хандуулж ажиллаж байна. “Багшийн хөгжил хөтөлбөр”- ийг 2017 онд баталсан байна. Үүний хүрээнд багшийн үйлчилгээний чанарыг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.
- Оюутанд зөвлөх үйл ажиллагаа нь сургалт, хүмүүжлийн үйл ажиллагааг бүхэлд нь хамарсан өргөн хүрээтэй ажил юм. Оюутанд зөвлөх үйл ажиллагаа нь байнга тасралтгүй системтэй явагддаг байна. Зөвлөх, хөгжүүлэх “Хаан кампус” үйлчилгээний төлөвлөгөөтэй байна.
- **Зөвлөх багш, сургалтын туслах ажилтан, сургалтын менежер, арга зүйч, байрны багш, эмч, сэтгэл зүйч нарын үйлчилгээний чанарын үнэлгээ, сайжруулалт**
- Оюутанд зөвлөх багш, сургалтын туслах ажилтан, сургалтын менежер, арга зүйч, байрны багш, сэтгэл зүйч нар үйлчилгээ үзүүлдэг бөгөөд үүнийг схемээр харуулсан байна.
- Үйлчилгээ, хүртээмжийн сайжруулах үүднээс ХААИС-ийн СБЗА-аас 2017 онд суралцагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авсан байна. Сургалтын үйлчилгээ, чанар, хүртээмжийн талаархи сэтгэл ханамжийн үзүүлэлтийг Сургалтын үйл ажиллагааны талаархи мэдээллийг хаанаас авдаг (1), номын сангийн үйлчилгээний чанар, хүртээмж (2), сургуулийн удирдлага, сургалтын сургалтын орчны чанар, үйлчилгээ (3) гэсэн гурван бүлэг асуулгаар авсан байна. Зарим нэгэн үзүүлэлтийг авч үзвэл (2) Номын сангийн үйлчилгээний чанар хүртээмид судалгаанд оролцсон нийт оюутнуудын 31,4 хувь сэтгэл ханамжтай, 30,8 хувь нь дунд зэрэг, 30,9 хувь нь огт ханамжгүй; (3) Сургалтын үйл ажиллагааны талаарх мэдээллийг зөвлөх багшаас хэрхэн авдаг вэ? гэсэн асуултад 45,3 хувь нь маш сайн, 26,1 хувь нь сайн, 15,6 хувь нь дунд 7,4 хувь нь муу, 5,8 хувь нь маш муу гэсэн үнэлгээ өгсөн.
- **Бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйн /зан үйл, зөрчил шийдвэрлэх, эрүүл аж төрөх г.м/ чиглэлүүдээр сургалт явуулж, ур чадвар олгодог байдал**

- ХААИС-ийн оюутан хөгжил хөтөлбөрийг хэрэгжүүлдэг, хөтөлбөрийн хүрээнд оюутны ёс зүй болон эрүүл аж төрөх чиглэлээр жил бүр сургалтыг 2010-2015 оны хичээлийн жилд жил бүр 1-2 удаа зохион байгуулсан байна.
- **Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлыг үнэлдэг байдал**
- Оюутнууд сайн дурын ажлыг идэвхтэй явуулж ирсэн байна. (2010-2011 – 5, 2011-2012-5, 2012-2013 – 8, 2013-2014- 8, 2014-2015 -8 сайн дурын ажил)
- Одоогоор оюутны сайн дурын ажлыг үнэлэх тодорхой үнэлэгээний систем байхгүй байна.
- **Суралцагч, төгсөгчдөд хөдөлмөрийн биржийн үйлчилгээ үзүүлдэг байдал**
- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв нь Агроэкологийн сургуультай 2014 оноос оюутан залуусыг түр ажлын байраар хангах, зуучлах зэргээр хамтран ажиллаж байна.
- **Суралцагчийн судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг дэмжин тусласан байдал**
- БОХТ хөтөлбөрийн тэнхмийн зүгээс жил бүрийн 3-р сард Оюутны эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, 1-5-р байрт шалгарсан оюутнууд бүрэлдэхүүн сургуулийн эрдэм шинжигээний бага хуралд шалгаран оролцдог байна.
- 2015 онд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймагт 11 оюутан дадлага хийсэн байна.
- 2010-2015 оны хооронд дипломын буюу судалгааны ажил хийсэн оюутны судалгааг гаргасан бөгөөд уг судалгааны дүнгээр жилээс жилд дипломын ажил бичих, хандлага нь нэмэгдсэнийг (2010-2011 – 6, 2014-2015 – 12 дипломын ажил, илтгэл) графикаар харуулсан байна. Мөн түүнчлэн солилцоогоор дадлага хийсэн, хуралд илтгэл тавьсан судалгааг гаргасан байна.
- Суралцагчийн судалгаа, шинжилгээний үйл ажиллагааны талаар ХААИС-ийн СБЗА –аас 2017 онд санал асуулга авч шинжилгээ хийж, үйл ажиллагааг сайжруулахаар ажиллаж байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан /Хэсэгчлэн хангасан /Хангаагүй**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Үйлчилгээ, хүртээмжийг сайжруулах үүднээс ХААИС-ийн СБЗА-аас 2017 онд суралцагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авсан байна. Сургалтын үйлчилгээ, чанар, хүртээмжийн талаарх сэтгэл ханамжийг судалгааг авч цаашид сайжруулах үйл ажиллагаанд хэвшүүлж байгаа нь сайшаалтай байна.
- Оюутанд үзүүлэх зөвлөх үйлчилгээ болон бусад үйл ажиллагааг хэрхэн сайжруулах арга замаа тодорхойлсон нь сайшаалтай.

**Анхаарах асуудал:**

- Оюутны сайн дурын ажлын үнэлэгээний системтэй болоход анхаарах.

#### **4.3 Оюутны байгууллагад үзүүлэх дэмжлэг**

Оюутны байгууллагаас санаачилсан нийгэмд үзүүлэх үйлчилгээг дэмжин хамтран ажилладаг байна.

**Үзүүлэлт нотолгоо:**

- **Оюутны сайн дурын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, дэмжсэн байдал**
- Оюутны зөвлөлөөс зохион байгуулдаг ажлын төлөвлөгөөг жил бүр бүрэлдэхүүн сургуулийн захирал баталж, холбогдох төсвийг олгодог байна.
- Оюутанд зөвлөх болон бусад үйл ажиллагааны сул талууд, засах аргаа тодрхойлсон байна.
- Байгал орчны хяналт үнэлгээ хөтөлбөрөөр суралцагчдын хувьд өөрсдийн мэргэжлийн чиглэлийн дагуу секц дугуйлан, клубт хамрагдах боломжтой. Энэ нь тэнхим, сургуулийн зүгээс оюутанд үзүүлдэг үр дүнтэй үйлчилгээ. АЭС-ийн Экологийн тэнхимээс нэр бүхий 5 дугуйлан, секц хичээллүүлдэг байна.
- **Оюутны байгууллагын үйл ажиллагааг явуулах төсөв, клубын үйл ажиллагааг дэмжих санхүүжилттэй байх, зориулалтын дагуу зарцуулдаг байдал**
- ХААИС-ийн Оюутны холбоо нь тодорхой хэмжээний санхүүжилтийг ХААИС-авдаг, хийсэн ажлын тайланг ХААИС-ын удирдлагад тайлагнадаг байна. Агроэкологийн сургуулийн Оюутны зөвлөл тодорхой хэмжээний санхүүжилт авдаг, тайланг бүрэлдхүүн сургуулийн удирдлагад тайлагнадаг байна. Гэвч тайлагнаж буй процесс ил тод бус байдаг байна.
- **Оюутны байгууллагын зүгээс санхүүгийн зарцуулалтаа ил тод тайлагнадаг байдал**
- ХААИС-ийн Оюутны холбоо нь тодорхой хэмжээний санхүүжилтийг ХААИС-авдаг, хийсэн ажлын тайланг ХААИС-ын удирдлагад тайлагнадаг байна. Агроэкологийн сургуулийн Оюутны зөвлөл тодорхой хэмжээний санхүүжилт авдаг, тайланг бүрэлдхүүн сургуулийн удирдлагад тайлагнадаг байна. Гэвч тайлагнаж буй процесс ил, тод бус байдаг байна.
- Цаашид энэ асуудалд анхаарал хандуулж, оюутнууд бие биедээ шаардлага тавьж, бүрэлдхүүн сургууль болон тэнхим нэгжүүд хамтран ажиллаж олон нийтэд ил тод болгох шаардлагатай байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй**

##### **Анхаарах асуудал:**

- Оюутны дугуйлан секц, клубүүдийн үйл ажиллагааг нийт оюутнуудад улам илүү хүртээмжтэй, ил тод болгоход анхаарах

##### **Зөвлөмж:**

- Бүрэлдэхүүн сургуулийн дэргэдэх Оюутны Зөвлөлийн үйл ажиллагааны төсөв, түүний зарцуулалтын тайланг ил тод болгох механизмыг боловсронгуй болгоход анхаарах

#### **4.4 Суралцагчийн урамшууллын тогтолцоо**

Суралцагчдын амжилтыг хөхүүлэн дэмжих урамшууллын системтэй байна.

##### **Үзүүлэлт нотолгоо:**

- **Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоо**
- Уг хөтөлбөрөөр 2010-2015 1112 оюутан суралцсан байна. 2010 онд хамгийн их буюу 18,37 %, 2014 онд 5.71 % нь ямар нэг тэтгэлэг хөнгөлөлтөнд хамрагдсан байна. Сүүлийн жилүүдэд төрийн сангийн зээлд хамрагдах оюутны тоо хязгаартай болсонтой холбоотойгоор хөнгөлөлтөд хамрагдагсдын тоо буурах хандлага байна.

- Нэн ядуу өрхийн суралцагч, малчин өрхийн нэг суралцагч, нэг өрхийн гурав дахь суралцагч, төрийн сангийн хөнгөлөлттэй зээлээр суралцагч, буцалтгүй тусламжаар суралцагч, төрийн албан хаагчийн суралцагч гэсэн хөнгөлөлтийн хэлбэрүүд байна. Үүнийг 2010-2015 оны байдлаар гаргасан байна.
- **Суралцагчдын үзүүлсэн амжилтууд**
- ХААИС-ийн Агроэкологийн сургуулийн хүрээнд 2010-2015 оны байдлаар спортын 39, урлагийн 3 медаль, гавьяа шагналыг хүртсэн байна.
- **Сургуулиас үзүүлж буй урамшуулал, дэмжлэг**
- ХААИС-ын улирлын шалгалтын журмын 7.3-д зааснаар “Ректорын нэрэмжит батламж”- ийг 3 ба түүнээс дээш авсан оюутан сургалтын төлбөрийн 20% -ийн хөнгөлөлтийн эрх авдаг байна. 2011-2015 онд нийт 15 оюутан, үүнээс 2012 онд 4, 2014 онд 4 хамгийн их тооны оюутан хөнгөлөлтийн эрх эдэлсэн байна.
- Байгаль орчны нөхөн сэргээлтийн ангийн суралцагчдын сургалтын төлбөрийг тодорхой хугацаагаар хойшлуулах, богино улирлын системээр хичээллэх болсноор төлбөрөө хуваан авах зэргээр уян хатан бодлого явуулж дэмжлэг үзүүлдэг байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Богино улирлын системээр хичээллэх болсноор төлбөрөө хуваан хийх боломж олгосон уян хатан бодлого явуулж дэмжлэг үзүүлдэг.

#### **4.5 Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

**Үзүүлэлт нотолгоо:**

- **Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэсэн байдал**
- ХААИС-д суралцаж буй оюутны шилжилт, хөдөлгөөнийг оюутны өргөдөл, хүсэлтийг үндэслэн шийдвэрлэдэг. Энэ нь ХАААИС-ийн бакалаврын сургалтын журамын 5.1, 5.2, 5.3, 5.4 заалтуудын дагуу зохицуулагддаг байна.
- **Шилжилт хөдөлгөөний судалгаа, дүгнэлт**
- 2010-2015 он хүртэл хичээлийн жил нэг бүрээр шилжилт, хөдөлгөөний судалгааг гаргасан байна.
- Суралцагчдын шилжилт, хөдөлгөөн хийх гол шалтгаан нь элсэгчид босго оноо багатай хөтөлбөрт элсэн орж, улмаар шилжих хөдөлгөөнөөр өөр мэргэжлийн ангийг сонгож болдог, их, дээд сургууль болон бүрэлдхүүн сургуулиудын хооронд шилжихэд төлбөр, хураамжийг чөлөөсөнтэй холбоотой гэж үзэж байна.
- Сургуулийн хэмжээнд шилжилт хөдөлгөөнөөр нэмэгдсэн оюутны тоо 274 үүнээс жилийн чөлөөн суралцсан 57.7%, 42.3 % шинээр нэмэгдсэн байна. Хасагдсан нийт 485 оюутнаас суралцах эрхээ хадгалж жилийн чөлөө болгосон 262 буюу хасагдсан оюутны 52 хувийг эзэлж байна.
- **Шилжилт хөдөлгөөнийг зохицуулж буй дүрэм, журам, гэрээний хэрэгжилт, суралцагчийн эрх ашгийг дээдэлсэн байдал**
- Оюутны шилжилт хөдөлгөөн болон бусад өргөдөл, хүсэлтийг цаг тухайд нь шийдвэрлэдэг байна, хүснэгтэд харуулснаар 100 % шийдвэрлэсэн байна

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй**



#### 4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

#### Шалгуур 5. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

##### 5.1 Багшийн сонгон шалгаруулалт, албан тушаал, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

##### Үзүүлэлт нотолгоо:

##### Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлого: тушаал, урамшууллын бодлого сонгон шалгаруулалт, хөгжүүлэлт, төлөвлөлт, хэрэгжилт:

- Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол, дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг, цолтой сургалт, заах арга зүйн өндөр, ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй.
- Хөтөлбөрийн багшлах хүний нөөцийн бололцоо нь хөтөлбөрийг хөгжүүлэх чухал хэсэг бөгөөд багшийн сонгон шалгаруулалт, багшийн албан тушаалын зэрэглэлд тавигдах шаардлага нь ХААИС-ийн захирлын 2014 оны 01-р сарын 29-ний өдрийн 23 тоот тушаалаар батлагдсан “ХААИС-д профессор багш ажиллуулах журам”-ын дагуу Боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, ХААИС-ийн дүрэмд нийцүүлэн зохицуулдаг байна. ([www.muls.edu.mn](http://www.muls.edu.mn))
- Хөтөлбөрт магистраас дээш зэрэгтэй багшийг нээлттэй сонгон шалгаруулж авдаг. Багшийн хөгжил хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлснээр багшийн мэргэжлийн болон хувь хүний ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, хөтөлбөрийн чанарыг сайжруулах нэг алхам болж байна. Багшийн хөгжил хөтөлбөр хэрэгжүүлэлтийн үр нөлөөг тухайлбал 2014-2015 оны хичээлийн жилд Агроэкологийн сургуулийн төгсөх ангийн оюутнууд багш нарын ур чадварыг 3.7 оноо буюу сэтгэл ханамжтай гэсэн үнэлгээ өгсөн байна. Сэтгэл ханамжин судалгаагаар маш их сэтгэл ханамжтай -63.1%, дунд -25.9%, огт сэтгэл ханамжгүй 11 %-ийг тус тус эзэлсэн байна.
- Байгаль орчныг хамгаалах технологи хөтөлбөр нь багшийн үйл ажиллагааг чадваржуулж, хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэгдсэн байдаг.
- Багшийн үйл ажиллагааны төлөвлөлтийг /PDCA/ хүснэгтээр үзүүлсэн байна.
- Багшийн үйл ажиллагааг багшийг нээлттэй сонгон шалгаруулах(1), багшийг тасралтгүй хөгжүүлэх (2), эрдэм шинжилгээ, судалгаа (3), багшийн үнэлгээ (4) гэсэн дөрвөн чиглэлээр гаргасан байна.
- Чиглэл тус бүрээр “Хаан кампус” стратегийн төлөвлөлт, түүний дагуу хийгдсэн ажлууд, төлөвлөлтийн хяналт үнэлгээ, сайжруулалтыг гаргасан байна.

##### Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин

- Хөтөлбөрийг хэрэгжүүлж буй профессор багш нар нь их, дээд болон мэргэжлийн сургуулийн багшид тавигдах нийтлэг шаарлагыг хангасан, эрдмийн зэрэг, цолтой, тухайн салбарын зөвлөх, тэргүүлэх зэрэглэлийн мэргэжилтнүүд ажиллаж байна. Тухайлбал: магистрант, докторантын түвшинд тэнхмийн зөвлөх профессор Монгол Улсын Гавьяат Багш Н.Эрдэнэцогт, гавьяат агрономч Х.Жамьяндорж нар хичээл зааж байна.
- Тухайн хөтөлбөрт хичээл заадаг 15 багшаас 11 багш буюу 73.3% доктор зэрэгтэй, 1 багш албан тушаалын профессор нийт багшийн 6.7%, 2 багш дэд профессор буюу 13.3%, ахлах багш 66.6% буюу 10 багш, 26.6 буюу 4

багш багшийн албан тушаалд, харин 3 багш дагалдан багшин орон тоон дээр ажиллаж байна.

**Багш суралцагчдын тооны зохистой харьцаа**

- Монгол улсын их, дээд сургуулиудын багш оюутны зохистой харьцаанаас уг хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа багш оюутны харьцаа хэвийн гэсэн ангилалд хамаарч байна. 2011 онд 9.8 байсан бол 2015 онд 6.6 болж буурсан байна. Мөн улсын дунджаас буурсан нь суралцагчдын тоо сүүлийн жилүүдэд буурсантай холбооой байна.
- Монгол улсын дундажтай харьцуулахад 50%-иас бага байгаа нь тухайн хөтөлбөрөөр суралцагчдад багш нэг бүрчлэн хүрч зөвлөх боломжтой болох нь харагдаж байна.

**Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг мөрддөг байдал**

- Багш нарын хэргжүүлж буй эрдэм шинжилгээ, инноваци, сургалт, үйлдвэрлэлийн ажлын туршлага, үр дүнг хамааран профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагжигч багш гэсэн 5 шатлалтай албан тушаал дээр хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байна.
- 2010-2016 оны хүртэлх хугацаанд 1 багш дэд профессороос професор, 1 багш ахлах багшаас дэд професор, 1 багш багшаас ахлах багш, 3 багш дадлагажигч багшаас багшийн оронд албан тушаал ахиснаас үзэхэд тэнхимийн багш нарын ур чадвар нэмэгдэж байгааг харуулж байна.
- Цол ахиулсан байдлыг АЭС-ийн Эрдмийн зөвлөлд тайлан бичүүлж, тэнхимд нээлттэйгээр сонсгол хийдэг.
- **Гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилан багш нарыг урамшуулдаг байдал**
- Багш нарын ажлын гүйцэтгэлийг сургалт, эрдэм шинжилгээ болон мэргэжлийн үйлчилгээ гэсэн 3 үзүүлэлтээр дүгнэдэг байна. Багш өөрөө болон удирдлагаас дүгнэн сургалтын болон заах аргазүйн шилдэг арга, аргачлалыг харилцан суралцах, багшлах арга зүйгээ сайжруулахад анхаардаг. Тухайлбал, багш нарын өөрийн үнэлгээний нэг үзүүлэлт нь ямар шинэ арга, аргачлалыг шинээр нэвтрүүлж ашиглаж байгааг тусгайлан тайлагнадаг явдал.
- ХААИС-ийн шилдэг багш шалгаруулах журмын дагуу сурган хүмүүжүүлэх ажилдаа өндөр амжилт гаргасан, тухайн хичээлийн жилд сургуулийн захиргаанаас дэвшүүлсэн зорилтыг биелүүлэхэд идэвх санаачлага гарган ажилласан, эрдэм шинжилгээ судалгааны ажилд ахиц гаргасан багш нараа тухайн жилийн “Тэргүүний багш”-аар өргөмжлөн шагнадаг уламжлалтай.
- 2011-2016 он хугацаанд 2 багш докторын төлбөрийн урамшуулал, 7 багш эрдмийн ажил бичих цалинтай чөлөө, илүү цагийн хөлс авсан байна /2011-2012-27, 2013-2014-30, 2015-2016-30/

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Төгсөх ангийн оюутнуудаас багш нарын ур чадварын талаар сэтгэл ханамжийн судалгаа авч, албан тушаалын зэрэглэл ахиулах, шагнал урамшуулалд тодорхойлоход тусган авч үздэг.

**Анхаарах асуудал:**

- 

**5.2 Багшийн хөгжил**

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

#### Үзүүлэлт нотолгоо:

- **Багшийн мэргэжил; заах арга зүйн ур чадвар; эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн түвшин; суралцах хэрэгцээг тодорхойлох судалгааг тогтмол хийдэг байдал**
- Багшийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд багшийн эрдэм шинжилгээ, судалгааны үр дүн, заах арга, ур чадварт оюутны сэтгэл ханмжийн судалгааг авч түүнд үндэслэн урт богино хугацааны сургалтад хамруулж байна. Тухайлбал 2014-2015 оны хичээлийн жилд Агроэкологийн сургуулийн төгсөх ангийн оюутнуудаас авсан судалгааны дүнгээс үзэхэд хичээл заалгасан багшийнхаа ур чадварт 3,7 буюу сэтгэл ханамжтай гэсэн үнэлгээ өгсөн.
- **Багшийн хөгжлийн хөтөлбөр, хэрэгжилт, дүн шинжилгээ, сайжруулалт**
- Багшийн хөгжил, мэдлэг, ур чадварын өсөлтийг ханган ажилахын тулд “ХААН КАМПУС” хөтөлбөрийн сургалт, судалгааны орчин, нөөцийг хөгжүүлэх зорилтын багш, ажилтнуудын чадавхийг хөгжүүлэх, захирлын үр дунгийн гэрээний дагуу баншийн хөгжлийг дараах үндсэн 3 байдлаар төлөвлөж ажиллаж байна. Үүнд:
  - Багшийн заах арга барил, чадварыг хөгжүүлэх
  - Багшийн мэргэжлийн чиглэлээр хөгжүүлэх
  - Багшийн хэлний мэдлэг, боловсролыг дээшлүүлэх
- Сургуулийн 2011-2015 онд хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнг тооцон гаргасан байна.
- **Багшийг үе шаттай хөгжүүлж, урт богино хугацаанд мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлж чадавхжуулдаг байдал**
- ХААИС нь багшийг тасралтгүй хөгжүүлэх бодлогыг үе уламжлан хөгжүүлж ирсэн. 2002 оноос эхлэн багш хөгжлийн хөтөлбөрийг боловсруулан багшийг тодорхой зорилго, чиглэлийн хүрээнд шат дараатай хөгжүүлэх бодлогыг амжилттай хэрэгжүүлж байна.
- Багшийн хөгжлийн хөтөлбөр, ХААИС-ийн багш бүр мэдлэгийн менежер байх зорилтуудын хүрээнд сүүлийн жилүүдэд эрдэм шинжилгээ, судалгааны орчин, материаллаг бааз нэмэгдэж, гадаадын хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх боломж нэмэгдэж байна.
- ХААИС-ийн багш хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд 2016 оноос эхлэн ХААИС-ийн багшийн чадамжийн хүрээг гаргасан. Үүнд: а) Мэдлэг оюуны чадамж, б) Менежментийн үр ашгийн чадамж, в) Судалгааны чадамж, г) Сургахуйн чадамж байна. Энэ хүрээ нь багшийг зөвхөн мэргэжлийн болон судалгааны ур чадварт хандуулах төдий бус хувь хүний хандлага, сургахуйн чадамжийг хөгжүүлэхэд ихээхэн анхаарч, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр зорилт тавин ажиллаж байна.
- **Гадаад, дотоодод туршлага судлуулсан байдал**
- Сүүлийн жилүүдэд их сургууль, бүрэлдэхүүн сургуулиас багш нарын гадаадад мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлж байгаа бөгөөд үүний үр дүнд сургалтад хамрагдагч багш нарын тоо өссөн байна. Гадаадад хамгаалсан багш нарын тоо нэмэгдэж байгаа нь эргээд төгссөн сургуульдаа мэргэжил дээшлүүлэх, гадаадын төсөл хөтөлбөрт хамрагдан дахин мэргэжил дээршлүүлэх байдал ихсэж байгаатай холбоотой.
- Гадаадын сургуультай хамтарсан төсөл хэрэгжиж уг төсөлд орж ажиллаж байгаа багш нар сургалтад хамарагдах болсон. Үүнд: Японы Китакуюшүгийн их сургуультай хамтарсан байгаль хамгаалах технологи төсөл, Япон Исланд, Солонгос, Герман улсын оюутнуудын зуны сургалтын хөтөлбөр зэрэг төслүүд байна.
- 2017 онд 2 багш Исланд улсын Рекиявик хотын Нэгдсэн Үндэсний их сургуульд хамтарсан сургалтын төлөвлөгөө боловсруулах чиглэлээр ажиллаад ирсэн байна.

- Дотоодын сургалтад давхардсан тоогоор нийт 130 багш хамрагдсан байна. Уг сургалтуудад хамрагдсан багш нарын ихэнх нь мэргэжил дээшлүүлэх чиглэлийн сургалтад хамрагдсан байна.
- 2015 онд тэнхимийн 6 багш БНАСАУ, ХБНГУ, АНУ, БНХАУ, Испани зэрэг өндөр хөгжилтэй орнуудад суралцаж, докторын зэрэг хамгаалсан байна.

### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

#### Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын үйл ажиллагааны чанарыг тасралтгүй сайжруулах чухал үзүүлэлтийн нэг болох багшийн хөгжилд анхаарч багшийн хөгжлийн хөтөлбөрийг 2017-2020, 2021-2023, 204-2026 он гэсэн 3 үе шатаар шинээр боловсруулан хэрэгжүүлж эхлээд байна.
- ХААИС-ийн багш хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд 2016 оноос эхлэн ХААИС-ийн багшийн чадамжийн хүрээг а.мэдлэг оюуны чадамж, б. менежментийн үр ашгийн чадамж, в. судалгааны чадамж, г. сургахуйн чадамж гэсэн 4 үзүүлэлтээр тогтоодог болсон.

#### 5.3 Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

##### Үзүүлэлт нотолгоо:

- **Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, патентийн тоо**
- Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нийт профессор багш нарын 47.1% судалгааны ажлыг идэвхтэй хийж байна.
- Оюуны өмчийн эрх, патент, технологи, стандарт, загварын тоо хэмжээ 2011-2013 онуудад 1-5 байгаа нь тухайн жилүүдэд багш нар өөрсдийн бүтээл, инноваци бүрт оюуны өмчийн баталгаажилт хийлгэдэггүй байсан нь харагдаж байна. Харин 2014, 2015 онуудад багш нарын оюуны өмчийн баталгаажилтын тоо өссөн байна. Сүүлийн 5 жилээр хангалтгүй байгаа боловч 2015 онд эрс нэмэгдсэн нь сайшаалтай байгаа боловч графикаар үзүүлсэн тоон үзүүлэлт тодорхойгүй байна..
- Цаашид оюуны өмчийн эрх бүхий бүтээл туурвих, патентын хүсэлт гаргах талаар дэмжлэг үзүүлэх, патентын сургалтыг судлаач багш нарт зориулан хийхээр төлөвлөж байна.
- **Захиалгат төсөл, гэрээт ажилд оролцсон байдал**
- Тэнхмүүд жил бүр салбарын өмнө тулгамдаж буй зорилтыг шийдвэрлэхтэй холбогдуулан улсын захиалга, болон олон улсын хэмжээний шинжлэх ухаан технологийн болон суурь судалгааны ажлуудыг боловсруулж гүйцэтгэсээр ирлээ.
- Сүүлийн 5 жилийн байдлаар 3 захиалгат төсөл, гэрээт ажилд гүйцэтгэсэн байна.
- Цаашид захиалгат төсөл, гэрээт ажилд оролцох багш, оюутнуудын тоог нэмэгдүүлэх, дагуулан сургах, тэдгээрийн үр дүнг тэнхимд сургалтын материаллаг бааз бүрдүүлэх ажилд чиглүүлэх төлөвлөгөөтэй байна.
- Дээрх төслүүд нь АЭС-ийн багш нарын боловсруулж, хэрэгжүүлж байгаа шинжлэх ухаан технологийн төсөл бөгөөд төслийн үр дүн нь ХАА- шинжлэх ухааны хөгжилд хувь нэмэр болоод зогсохгүй АЭС-ийн эрдэмтэн багш нарын мэргэших, мэргэжлийн чадвараа дээшлүүлэхэд онцгой нөлөөтэй.
- **Судалгааны ажлын үр дүнгээр хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүй; судалгааны ажил шинэчлэгдэн хөгжсөн байдал**
- БОХТ хөтөлбөрийн багш нар сургалтын үйлдвэрлэлтэй холбон ажиллах зорилгоор судалгааны олон чиглэлд төсөл, хөтөлбөр, гэрээт болон захиалгат ажлыг гүйцэтгэж байна. Эдгээр ажлын хүрээнд багш нарын мэдлэг, мэдээлэл, гадаад харилцаа хөгжих, оюутнуудын дадлагажих, онолын мэдлэгээ үйлдвэрлэлд

бататгах, гадаад хэлний мэдлэгээ сайжруулах зэргээр тухайн хөтөлбөр өөрөө өөрийгөө хөгжүүлэх нөхцөл бүрэлдэж байна.

- Үйлдвэрлэлийн дадлага, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх бааз нэмэгдсэн, дадлага хичээлүүдийн багц цаг нэмэгдсэн нь хөтөлбөрийн чанар сайжрахад ахиц болсон /Байгалийн нөөцийн ашиглалтын эрх зүй, Ургамлын экологи, үнэлгээ, БОНБУ/
- **Үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн байдал**
- Агроэкологийн сургууль жил бүр багш, оюутны эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж судалгааны бүтээл, үр дүнг АЭС-ийн “Эрдмийн бичиг” бүтээлд хэвлүүлдэг байна.
- Судалгааны ажил ишлэгдсэн байдлын тухай мэдээлэл байхгүй.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан /Хэсэгчлэн хангасан/Хангаагүй**

**Анхаарах асуудал:**

- Оюуны өмчийн эрх, патент, технологи, стандарт, загварын тоог тодорхой болгох
- хичээлүүдийн хөтөлбөрүүдийг 3-тын кредит системд шилжүүлж шинэчлэн боловруулсан, шилжүүлэх болсон үндэслэл, үрдүнг тодруулах

**- Зөвлөмж:**

- Багш нарын хэвлүүлсэн эрдэм шинжилгээний бүтээлийг нэгтгэн харуулсан хүснэгт тайланд оруулах.

#### **5.4 Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

**Үзүүлэлт нотолгоо:**

- **Өөрийн үнэлгээний тайлан**
- Багшийн өөрийн үнэлгээний тайланг сургалт, заах арга зүй (1), эрдэм шинжилгээний үйл ажиллагаа (2), мэргэжлийн үйлчилгээ (3), сургууль, олон нийтэд үзүүлэх үйлчилгээ (4) гэсэн үндсэн 4 үзүүлэлтээр бичиж 1-5 баллаар дүгнэж, сургуулийн нийт багш нарын дунд хэлэцүүлэн, тэнхим болон сургуулийн удирдлагаас үнэлгээ авч өөрийн үйл ажиллагааг хэр бодитой болохыг дүгнэсэнээ харьцуулан цаашид ажлаа сайжруулан ажилладаг.
- 20015-2017, 3 жилийн туршид багш нарын өөрийн үнэлгээний дүн болон удирдлагаас өгсөн үнэлгээг хүснэгтээр харуулсан байна. /х 181/
- Судалгаагаар доктор зэрэгтэй ахлах багш нарын хувьд өөрсдийн болон удирдлагуудаас өгсөн үнэлгээ дунджаар 95 хувийн, бусад багш нарын хувьд 75-85 үнэлгээтэй байна.
- **Багшийн хөндлөнгийн үнэлгээ /Аттестатчлал, эрэмблэлт, чансаа тогтоолт/**
- ХААИС-ийн удирдлага, сургалтын албанаас дотоод хяналтыг сайжруулах зорилгоор ХААИС-ийн профессор багшийг аттестатчлах журмыг боловсруулан мөрдөн ажилласнаар хамт олны бүтээлч үйл ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулдаг. ХААИС-ийн профессор багшийг аттестатчлах журмын шлгуур үзүүлэлт тодорхой байдаг нь профессор багш нарт өөрийн зэрэглэлийг ахиулахад таатай нөхцөл бүрддэг гэжээ.
- ХААИС-ийн багшийн ажлын үнэлгээний журмыг мөрдөн ажилладаг. Үүний дагуу 3 жил тутам багшийг аттестатчилж тухайн зэрэглэлд тавигдах шаардлагыг мөрддөг байна.
- Мөн багш өөрөө хугацаанаас өмнө саналаараа хүсэлт гаргаж ажлыг дүгнүүлж зэрэглэл ахиулах боломжтой байна.

- Аттетатчилал нь 2 хэлбэрийн үнэлгээнд тулгуурлан явагддаг. Үүнд: 1. Өөрийн үнэлгээ, 2. Хөндлөнгийн үнэлгээ; 3.Сургалтад ашиглаж буй сургах/заах аргын үр дүн, үр нөлөөний судалгаа: мөн түүнчлэн гадаад хэл, мэдээллийн технологи, эрх зүйн үнэлгээ хамаарагдана.
- ХААИС-ийн профессор багшийг аттестатчлах журмын дагуу дадлагажигч багш 1-2 жил ажиллаад багшийн зэрэглэлд, багшаар 2-3 жил ажиллаад ахлах багшийн зэрэглэлд, ахлах багшаар 3-5 жил ажиллаад дэд профессорын зэрэглэлд тус тус аттестатчилалд оруулдаг тул шалгуур үзүүлэлтүүдийг биелүүлэхийн тулд багш бүр өөрийн хүч чадлаа дайчлан ажиллаж үйл ажиллагаагаа зайлшгүй сайжруулах шаардлагатай болдог байна.
- Тэнхмийн багш нарын хувьд зэрэглэл, шатлал ахиагүй тохиолдол сүүлийн 5 жилийн туршид гарч байгаагүй байна.
- Экологийн тэнхмийн багш нарт оюутнуудын өгсөн үнэлгээг тусгасан байна. Сургуулийн бүх хөтөлбөрт сэтгэл ханамжийн үнэлгээ дундаж 3,75-3,85 бол уг хөтөлбөрийн багш нар 3,43-3,65 байгаа нь сургалтын бүтээлч арга ашиглах, үр чадвараа нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.
- **Сургалтад ашиглаж буй сургах/заах аргын үр дүн, үр нөлөөний судалгаа**
- **Тайлан, судалгааг хэлэлцэж, дүгнэлт гаргасан байдал**
- ХААИС-ийн багш нарын ажлын үр дүнг өөрийн үнэлгээний тайланг үндэслэн дүгнэлт өгөхөөс гадна аттестатчилалд оруулж дүгнэдэг. Аттестатчлалын үр дүнгээр цалин хөлсийг нь тогтоох бөгөөд зарим багш нар хангалтгүй дүн үзүүлсэн нөхцөлд хугацаатай үүрэг өгч биелэлтийг нь шалган ажилладаг.
- 2014 онд явуулсан аттестатчлалаар багш Х.Ганчимэг, Н.Мягмарсүрэн, С.Цогт, А.Сайнчулуу нар хангалттай үзүүлэлтгүй байсан тул хугацаатай үүрэг өгч ажилласны дүнд С.Цогт багшийн зэрэглэлээс ахлах багш, А.Сайнчулуу, Х.Ганчимэг нар дадлагжигч багшаас багшийн зэрэглэл рүү ахиж дэвшсэн. Одоо Н.Мягмарсүрэн багш дадлагжигч багшийн зэрэглэл дээр ажиллаж байна.
- **Сургалтад оролцогчдоор багшийг үнэлүүлэх**
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нар нь ХААИС-ийн профессор багшийг аттестатчлах журам, ХААИС-ийн багшийн ажлын үнэлгээний журмыг мөрдөн ажилладаг. Аттестатчлалыг хоёр хэлбэрийн үнэлгээнд тулгуурлан явуулдаг. Үүнд: 1. Өөрийн үнэлгээ, 2. Хөндлөнгийн үнэлгээ. Мөн гадаад хэл болон компьютер-мэдээллийн технологи, эрх зүйн үнэлгээ хамрагддаг.
- Сургалтын нэгдсэн албанаас сургалтад оролцогч оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгааг жил бүр авдаг. Тухайлбал 2014-2016 оны хичээлийн жилийн судалгаагаар 2015-2016 онд сэтгэл ханамж 3,7, 2015-2016 онд 3,8 үзүүлэлттэй, сургуулийн бүх хөтөлбөрийн дундаж 3,43-3,65 байна.
- **Багшийн бүхий л үйл ажиллагааны баримт, материал**
- Багшийн үйл ажиллагааны баримт материалд дараах зүйлс багтдаг. Үүнд:
  - Заадаг хичээлийн сургалтын төлөвлөгөө, стандарт
  - Заадаг хичээлийн иж бүрдэл /конспект, гарын авлага, ашиглах бусад нэмэлт материал/
  - Е хичээлийн иж бүрдэл
  - Журнал
  - Үйл ажиллагааны төлөвлөгөө
  - Стратеги төлөвлөгөө зэрэг материалууд байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй**

#### **Анхаарах асуудал:**

- Судалгаагаар доктор зэрэгтэй ахлах багш нарын хувьд өөрсдийн болон удирдлагуудаас өгсөн үнэлгээний үндэслэлийг тодорхой болгох

#### **5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: бүрэн хангасан**

## Шалгуур 6. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

### 6.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

#### Үзүүлэлт нотолгоо:

- **Оролцогч болон сонирхогч талуудын эрэлт хэрэгцээ ба агуулгын харьцуулсан шинжилгээ**
- 2014-2015 оноос эхлэн сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн үйл явцыг бодитой, оролцоотой хүртээмжтэй зохион байгуулах зарчмыг баримтлан ажилласан байна.
- ХАА, байгаль орчны чиглэлийн төрийн захиргааны дээд байгууллагууд, ажил олгогчид төгсөгчид, мэргэжлийн байгууллагууд, гадаад хамтын ажиллагаатай их сургуулиуд, судлаачид, профессор багш, оюутнуудыг хамарсан семинар, зөвлөгөөн 8 удаа зохион байгуулсан материалтай танилцав.
- Хөтөлбөрийг шинэчлэхэд оролцогч, сонирхогч талуудаас сэтгэл ханамжийн судалгааг 2014-2015, 2015-2016, 2017 онуудад авч хамаарлын шинжилгээ хийж тусгасан байна.
- Хөтөлбөрийг боловсруулахдаа гадаадын 23 их, дээд сургуулийн хөтөлбөрийг судалсны зэрэгцээ АНУ-гийн Пурдугийн их сургууль, Японы Китадюошу хотын их сургууль, МУИС, ШУТИС, МҮИС ба Эко Ази зэрэг сургуулиудын сургалтын төлөвлөгөөний бүтэцтэй харьцуулан судласан байна.
- **Сургалтын агуулга нь хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцсэн байдал**
- 2014 онд БОХТ мэргэжлээр суралцаж буй 67 оюутнаас хөтөлбөрийн агуулгын талаар хичээлүүдийн агуулга зах зээлийн шаардлагыг хангадаг эсэх (4.1), хичээлүүдээр олж авсан онолын суурь мэдлэг (4.2), ур чадвар (4.3) хангалттай эсэх, хичээлүүд нь орчин үеийн чиг хандлагад нийцдэг эсэх (4.4), мэдлэг, ур чадвар бусад сургуулиудтай өрсөлдөх чадварын үнэлгээ зэрэг (4.5) 5 шалгуур үзүүлэлтээр сэтгэл ханамжийн судалгаа авч үнэлгээ хийсэн байна. Үр дүн нь сургуулийн дундаж үзүүлэлтээс доогуур гарсан тул сургуулийнхаа дундаж үзүүлэлтэнд хүргэх талаар анхаарч ажиллах хэрэгтэй байна.
- **Суралцагч хичээл, багшийг сонгон суралцдаг байдал чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.**
- 2011 оноос оюутнууд хичээлээ ангиараа сонгодог байснаа 2015 оноос суралцагч сурах хуваарийг өөрөө төлөвлөн хичээл, багшийг сонгонх боломжийг бүрдүүлсэн удирдлага мэдээллийн ULMS систем ашиглах болсон байна.
- Хичээл сонголт 1-ээр судлах улирал хичээлээ, сонголт 2-оор багш болон хувиараа сонгодог байна.
- **Хөтөлбөр дэх хичээлийн хэлбэр, онол, практикийн зохистой харьцааг хангасан байдал**
- БОХТ хөтөлбөрийн онол, практикийн зохистой харьцааг сайжруулах үүднээс 2015 онд төгсөгчдөөс сэтгэл ханамжийн судалгаа авч сургалтын төлөвлөгөө, хичээлийн стандарт хөтөлбөрүүдийг шинэчилсэн байна.
- **БОХУ мэргэжлээр:** Ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлүүдийнхээ сургалтын стандартыг дэлхийн чиг хандлагад нийцүүлсэн.
- **БОНС мэргэжлээр:** Нөхөн сэргээлтийн сургалтын төлөвлөгөөнүүдэд дадлага ажлын цагуудыг нэмэгдүүлсэн.

**УНБУ мэргэжлээр:** Ургамлын нөөц, удмын санг хамгаалах, хэрэглээнд оруулах, ургамлыг бусад нөөцтэй нь холбоотой хамгаалах агуулгыг сургалтын төлөвлөгөөнд нэмж тусгасан

- 2011 онд сургалтын төлөвлөгөөнд сургалт, үйлдвэрлэлийн дадлага 7,2 % байсан бол 2015 онд 15%-ийг эзлэх болж нэмэгдсэн нь суралцагсдын мэдлэг чадвар, дадлыг нэмэгдүүлэхэд түлхэц болсон байна.
- **Үйлдвэрлэл, практик, клиник сургалтын агуулгыг хамтран хэрэгжүүлдэг байдал**
- Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулан 1-3-р дамжаанд сургалт үйлдвэрлэлийн дадлагыг мэргэжлийн онцлогт тохируулан хийхийн зэрэгцээ төгсөлтийн ажлуудыг хийлгэн судалгааны ажлын үр дүнг нэвтрүүлэх чиглэлээр үйлдвэрлэгчидтэй хамтран ажилладаг байна.
- БОХУ мэргэжлийн оюутнууд үйлдвэрлэлийн дадлагаар технологийн дамжлага бүрээс гарах хог хаягдал, бохирдол, эвдрэлийг тодорхойлон байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах зөвлөмж боловсруулан үнэлгээ хийх, нөхөн сэргээлтийн мэргэжлийн оюутнууд үйлдвэрлэлд шинэ техник технологи, шийдлийг зөвлөмжлөх, турших чиглэлээр ажилладаг байна.
- Биологийн хичээлийн дадлагыг Төв аймгийн Батсүмбэр сум дахь дадлагын баазад, экологийн хээрийн дадлагыг Төв аймгийн Батсүмбэр, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумууд дахь дадлагын баазуудад тус бүр 30 хоног, үйлдвэрлэлийн дадлагыг Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотууд болон Төв, Сэлэнгэ аймгуудын томоохон хөнгөн, хүнс, ХАА, уул уурхайн үйлдвэрүүдэд 2 шатлалаар хийдэг байна.
- Дадлагаар байгалийн нөөцийг хамгаалах, ашиглахад хяналт тавих, эрх зүйн зөрчлийг илрүүлэх, бүртгэх, хариуцлага тооцох, сөрөг үр дагаварыг арилгах арга хэмжээ авах, түүний хэрэгжилтэнд хяналт тавих, байгаль орчны стандарт, ISO, экологийн паспортын талаар танхимд олсон мэдлэгээ амьдрал дээр хэрэглэх боломж, арга замуудыг суралцдаг байна.
- Үйлдвэрлэлийн явцад байгальд хал багатай байх, альтернатив хувилбарыг санал болгох замаар зөв гарц, шийдлийн талаар багаар дүгнэлт гаргаж байгааг үндэслэн оюутны мэдлэг чадварыг дүгнэж үнэлдэг байна.
- **Зайны болон цахим хичээлүүдийг E- контент түвшинд боловсруулан сургалтад ашигласан байдал**
- 2013 оноос хойш бүх хичээлүүдээр “Presentation”, “E-book”, “E-Test”- тэй болсон байна.
- **Хичээл хоорондын уялдаа, залгамж холбоог хангасан байдал**
- БОХТ хөтөлбөрт хамаарах 4 мэргэжлийн хөтөлбөрийн хичээл хоорондын уялдаа, залгамж холбоог хангасан байдлыг матриц ашиглан анализ хийж, давхардлыг засварлан өөрчилсөн байна.

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- “Ногоон хөгжил” студи сургалтын студи байгуулан ажиллуулдаг.
- Бүх багш нарын 1 минутын, хичээлүүдийн 20 минутын товч видео танилцуулга хийсэн

#### **6.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- **Сургалтын арга зүйг боловсруулсан баримт бичиг, загвар**
- БСШУЯ-ны 2014 оны 4-р сарын 28-ны өдрийн А/74 тоот тушаалаар батлагдсан дээд боловсролын бакалаврын мэргэжлийн чиглэлд тавих нийтлэг шаардлагын



дагуу БОХТ хөтөлбөрийн Байгаль орчны хяналт, үнэлгээ, Байгаль орчны нөхөн сэргээлт, Ургамлын нөөц, био үйлдвэрлэл мэргэжлийн сургалтын төлөвлөгөөг боловсруулсан байна.

- Сургалтын хөтөлбөрийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үр дүнд суурилсан идэвхтэй аргыг хэрэглэхээр төлөвлөн явуулах схемийг боловсруулсан байна.
- **Сургалтад ашиглаж буй арга зүй нь мэдлэг бүтээлгэж, хэрэглэж сургахад чиглэсэн байдал**
- Идэвхтэй сургалтын аргын бүдүүвчийг харуулсан байна.
- Сургалтын арга зүйд Кейст суурилсан сургалт (Case-based leaning), асуудалд суурилсан сургалт (problem-based leaning), зориулагдсан орчинд суурилсан сургалт (Studio-based leaning), туршилтанд суурилсан сургалт (Experimental leaning), тоглох ба симуляц хийх сургалт (Gamification-based leaning), зохиол/түүхэн явдалд суурилсан сургалт (Scenario/story-based leaning) гэх мэт 8 сургалтын аргыг хэрэглэдэг байна.
- Жишээ болгон байгалийн нөөц ашиглалтын эрх зүйн хичээлээр гарч буй зөрчил, гэмт хэрэг дээр кэйс өгч багаар ажиллуулах ба шүүх хурал хийж прокурор, өмгөөлөгч, ялтан, сэжигтэн, хэрэгт холбогдогч, эрх бүхий албан тушаалтны дүрд тоглуулах зэргээр оюутны идэвхтэй байдлыг өдөөн ажилласнаар урам, идэвх нь сэргэж сургалтын чанар сайжирч байгааг тэмдэглэсэн байна.
- Гэвч ямар хичээлүүдэд ямар аргыг голчлон хэрэглэх тохиромжтой талаар дүгнэлт хийгээгүй, сургалтын арга, хэлбэрийг хооронд нь холисон зэрэг дутагдал ажиглагдлаа.
- **Сургалтад хэрэглэж буй мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, программ хангамж, техник хэрэгслийн ашиглалтын судалгаа**
- Arc View 3.2, Arc GIS 9.2, Erdas Imagine 8.48, Envi 4.3, Auto CAD 2007, Auto CAD, Arch CAD програм хангамжуудыг сургалтанд ашигладаг байна.
- 2011 онд 7 лабораторитой байснаа 2016 онд 2 лаборатори, 9 тоног төхөөрөмж шинээр авсан гэсэн байна.
- Лаборатори хангамжийн болон мэргэжлийн лабораториудын хичээлийн шаардлагад нийцдэг эсэх талаар 912 оюутнаас сэтгэл ханамжийн судалгаа авахад 69 буюу 7.4 % нь маш сайн, 186 буюу 20.4 % нь сайн, 299 буюу 32.8 % нь дунд зэрэг, 153 буюу 16.8 % нь муу, 205 буюу 22.5 % нь маш муу гэсэн үнэлгээ өгсөн байна. Иймд энэ талаар цаашид анхаарч ажиллах хэрэгтэйг харуулж байна.
- **Сургалтын арга зүйн судалгаа, дүгнэлт, хөгжүүлдэг байдал**
- Агроэкологийн сургууль жил бүр хичээлийн улирлын төгсгөлд багш нарын сургалтын арга зүй, мэдлэг чадвар шаардлага хангаж буй эсэх талаар оюутны сэтгэл ханамжийн судалгаа авч дүгнэн үнэлгээ өгч арга зүйг хөгжүүлэх талаар анхааран ажилладаг байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Лабораторийн орчин үеийн шинэ зарим төхөөрөмжийг авч сургалт, судалгаанд хэрэглэж байна.

**Анхаарах асуудал:**

- Сургалтын арга, хэлбэрийг хооронд нь ялгаж хэрэглэх.

### **6.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн дүүрэн, үнэлдэг арга зүйтэй, түүнийг байнга сайжруулдаг байна.

**Үзүүлэлт нотолгоо:**

- **Мэдлэг, ур чадвар, хандлагын түвшин тогтоох, ахиц дэвшлийг үнэлэх үнэлгээний арга, аргачлал, хэрэглээ**

- ХААИС 2007, 2012, 2015 онуудад оюутны мэдлэг, чадварыг дүгнэх журмыг шинэчлэн боловсруулжээ. ХААИС-ийн захирлын 2015 оны 10-р сарын 14-ний өдрийн А/326 тоот тушаалаар бакалаврын сургалтанд мөрдөх шинэ журмыг баталж хуучин журмыг хүчингүй болгосон байна. 2015-2016 оны хичээлийн жилээс богино улирлын системд буюу 4 үндсэн, 2 нэмэлт улирлаар хичээллэх, оюутны мэдлэг, чадварыг дүгнэх онолын мэдлэг-40%, мэргэжлийн ур чадвар -40%, хувь хүний хандлага, ур чадвар, үр дүнгийн сорил-20 % гэсэн системийг хэрэглэдэг байна.
- Энэ хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутнуудыг Рубрикийн аргаар үнэлдэг байна.
- **Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл нэг бүрийн үнэлгээний арга, хэлбэр нь суралцагчдыг тасралтгүй хөгжихөд хөтөлдөг байдал**
- Оюутныг багаар ажиллуулах, илтгэл тавиулж хэлэлцүүлэх, бие даалтыг тогтмол шалгаж хэлэлцүүлэн үнэлэх талаар оюутнуудаас судалгаа авч дүгнэхэд 3.94, 3.49, 3.93 гэсэн дундаж үнэлгээ өгсөн байна.
- Оюутны мэдлэгийн түвшний стандарт үнэлгээний болон үнэлэх арга зүйг хүснэгтээр харуулсан байна.
- **Суралцагчийн үнэлгээ нь ил тод, найдвартай, шударга, ижил тэгш зарчмыг хангасан байдал**
- Оюутны мэдлэг, чадварыг үнэлэх журам ил, тод, найдвартай, эрх тэгш зарчмыг хангасан талаар 1934 оюутнуудаас 2011 онд авсан сэтгэл ханамжийн судалгаа харуулсан боловч энэ нь ерөнхий ил, тод, найдвартай, эрх тэгш зарчмыг тус бүрд нь харуулаагүй байна. Түүнээс хойш авсан судалгаа байхгүй байна.
- **Суралцагчийн гаргаж буй амжилтууд**
- 2008-2009, 2010-2011, 2011-2012, 2012-2013, 2014-2015 хичээлийн жилүүдийн суралцагчдын голч дүнгийн судалгааг оруулсан байна. Жишээ болгон үзүлсэн БОХУ мэргэжлийн 1-4-р дамжааны нийт оюутны дундаж голч дүнгийн сүүлийн 5 жилийн харьцуулалтаас харахад 2010-2011 оны хичээлийн жилийнхээс 2014-2015 онд 0.14 –өөр өссөн байна.
- Амжилттай суралцаж захирлын нэрэмжит хуудас авсан оюутны тоо дамжаа бүрээр өөрчлөгдөж байсан боловч нийт дүнгээрээ өссөн байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан /Хэсэгчлэн хангасан/Хангаагүй**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Сургалтанд богино улирлын системийг нэвтрүүлж, энэ талаар багш оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авч давуу ба сул талуудыг тодорхойлж цаашид хэрэгжүүлэх санал боловсруулсан байна.

Хөтөлбөрийг сайжруулах талаар оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааг хангалттай хийж санал дүгнэлтийг хөтөлбөрийн шинэчлэлд тусгадаг.

- Хөтөлбөртөө дадлага ба бие даалтын багтаамжийг нэмэгдүүлсэн.
- Хичээлээр хувь хүний ур чадвар хандлагыг үнэлэх рубрикийн загварыг өөрийн нөхцөлд тохируулан ашиглаж байна.

#### **Анхаарах асуудал:**

- Хичээлийн улирал бүрийн сурлагын голч дүнгийн харьцуулалтыг мэргэжил бүрээр тогтмол гаргаж дүн шинжилгээ хийж байх хэрэгтэй.

#### **Зөвлөмж:**

- Оюутны мэдлэг чадварыг үнэлэх талаар оюутнуудаас судалгаа авахдаа ил тод, шударга, эрх тэгш гэсэн 3 үзүүлэлтийг нэмж оруулах

### **6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## **Шалгуур 7. Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө**

Хөтөлбөрийн үр дүн нь сургуулийн эрхэм зорилго, зорилтыг хангаж, сонирхогч талуудын эрэлтэд нийцсэн, үнэ цэнэтэй байна.

### 7.1. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

#### Үзүүлэлт нотолгоо:

- **Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, ажлын байрны нийцлийн судалгааг тогтмол явуулж, хөтөлбөрийн шинэчлэлд тусгаж хэрэгжүүлдэг байдал**
- 2014 оноос эхлэн төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал, мэдлэг ур чадвар ажлын шаардлагад хэрхэн нийцэж байгаа талаар ажил олгогчдоос сэтгэл ханамжийн судалгаа авч ажилласан байна.
- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаанаас харахад 65.7 % нь мэргэжлийн дагуу, 11.7 % мэргэжлийн бус байгууллагад ажиллаж, 17.7 % нь ажил эрхэлж байгаа эсэх нь тодорхойгүй болон эрхлээгүй гэсэн дүгнэлт гарсан байна.
- Төгсөгчдөөс сургалтын хөтөлбөртөө сэтгэл ханамжийн судалгаа авч үр дүнд нь тулгуурлан сургалтын төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулсан байна.
- **Төгсөгчид, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа**
- Агроэкологийн сургууль төгсөгчдөөс (123) мэдлэг, ур чадвар, түүний хэрэглээтэй холбоотой 11 чиглэлээр сэтгэл ханамжийн судалгаа авахад 18.6 % нь ханамжтай, 28.9 % нь дунд зэрэг 52.5 % нь ханамжгүй гэсэн үнэлгээ өгсөн байна.
- Мөн төгсөгчдөөс хичээлийн онол, семинар, дадлагаар олж авсан мэдлэг, хичээлүүдийн агуулга, сэдвийн давхцал, материаллаг бааз, багш нарын мэдлэг, ур чадвар, заах арга зэргээр сэтгэл ханамжийн судалгаа авсан үр дүнг оруулсан байна.
- **Төгсөгчид ажлын байраар хангагдах хүртлээ хүлээхэд зарцуулах дундаж хугацаа**
- Тухайн хөтөлбөрөөр бэлтгэсэн төгсөгчдийн хувьд 6 сарын дотор ажлын байраар хангагдах нь чухал гэсэн бөгөөд судалгаанаас харахад 1-1.5 жил байна гэсэн байна.

#### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчид, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааг хангалттай тогтмол авдаг.

### 7.2.Хөтөлбөрийн үр нөлөө:

Хөтөлбөр үр дүнгээ үнэлүүлэх, үнэ цэнээ тодорхойлох, ахиц дэвшлээ харуулах нотолгоотой байна.

#### Үзүүлэлт нотолгоо:

- **Хөтөлбөрөөр төгсөгчдийн амжилтууд**
- Төгсөгчдийн 21.9 % нь ХААИС болон бусад их сургуульд магистрантур, докторантурт элсэн суралцдаг байна. Жишээлбэл 2009 онд төгссөн Б.Шүрэнцэцэг 2012 онд, 2013 онд төгссөн Т.Билгүүнтөгс 2015 онд магистрын зэрэг хамгаалаад 2014, 2015 онуудад докторантурт элсэн суралцсан байна.
- 2009 оны төгсөгч С.Сайнбаяр БОХУ-ний СТ ХХК-ийн захиралаар, 2010 оны төгсөгч С.Нямжав улсын байцаагчаар тус тус ажиллаж байна.
- Өмнөговь аймгийн БОАЖГ-ын уул уурхай, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Б.Оргилмаа сүүлийн 5 жил дараалан Байгаль орчны шилдэг мэргэжилтнээр шалгарч байсан.

- **Салбар, хөдөлмөрийн зах зээлд эзлэх байр суурь**
- Хөдөлмөрийн яамны ХЭҮТ-ийн мэдээлэл хяналт, үйлчилгээний алба 2013 онд зах зээлийн төлөв байдалд хийсэн судалгаандаа мэргэжлийн ангиллыг ажил мэргэжлийн үндсэн бүлгээр авч үзээд Байгаль орчныг хамгаалах технологи хөтөлбөрийг тус ангиллын Хүрээлэн буй орчны хамгаалал, ашиглалт, хяналт үйлчилгээ гэсэн салбарт багтаасан байна.
- Энэ хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр элсэгчдийн тоо нэмэгдэж байгаа нь хөдөлмөрийн зах зээл дээр энэхүү мэргэжлийн эрэлт хэрэгцээ их байгааг харуулж байна.
- **Мэргэжлийн салбарын хөгжилд оруулсан хувь нэмэр /Төрийн болон ТББ-ын зүгээс хийсэн үнэлгээ, судалгаа/**
- Ажил олгогчдын зүгээс төгсөгчдөд 2015 онд хийсэн сэтгэл ханамжийн судалгаанаас харахад 75.8 % нь сэтгэл ханамжтай, 19.8 % нь дунд зэрэг, 4.4 % нь ханамжгүй гэсэн үнэлгээ өгсөн байна.
- Ажил олгогчидтай хийсэн уулзалтын үед ХААИС-ийн БОХТ хөтөлбөрөөр төгсөгчид бусад сургуулийн энэ чиглэлийн мэргэжлээр төгсөгчдөөс нөхөн сэргээлт ба байгаль орчны үнэлгээний талаар илүү мэдлэг, чадвартай байна гэсэн дүгнэлт өгч байв.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй Онцлог зүйл/Туршлага:**

- Ажил олгогчидтой хийсэн уулзалтын үед ХААИС-ийн БОХТ хөтөлбөрөөр төгсөгчид бусад сургуулийн энэ чиглэлийн мэргэжлээр төгсөгчдөөс нөхөн сэргээлт ба байгаль орчны үнэлгээний талаар илүү мэдлэг, чадвартай байв

**Зөвлөмж:**

- Тандан судлалт сайн хийж, төгсөгчдийн амжилтын талаар мэдээлэл сайн авч байх

**7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

**Үзүүлэлт нотолгоо:**

- **Суралцаж буй гадаад оюутны тоо**
- 2016-2017 оны хичээлийн жилд БНЛУ-ын оюутан N.Khambounlerd (7014091) БОХТ хөтөлбөрт, 2017-2018 оны хичээлийн жилээс Герман улсын магистрант Vanessa Julia Rothkegel мөн хөтөлбөрөөр 5 хичээл суралцаж байна. 2016-2017 хичээлийн жилд Чех улсын магистрант Lukas Zahogec Биологийн төрөл зүй хамгааллын чиглэлээр зочин судлаачаар ирж ажилласан.
- **Олон улсын хамтарсан хөтөлбөрийн хэрэгжилт**
- БОХТ хөтөлбөрөөр 2011 оноос эхлэн ОХУ-ын Эрхүүгийн ХААИС, Новосибирскийн ХААИС-иудтай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж 15 оюутан хос хөтөлбөрийн дипломтой төгссөн байна. Цаашдаа Буриадын ХАААкадеми, Германы Вейнштефаны их сургууль, Өвөр монголын Тариалангийн их сургуулиудтай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.
- **Улсын болон олон улсын чанартай олимпиад, уралдаан тэмцээнд үзүүлсэн амжилт**
- 2011-2015 онд улсын хэмжээнд зохиогдсон “Мөрөөд бас дахин мөрөөд” эссэ бичлэгийн, “Миний мэргэжил-Миний аз жаргал”, “Бидний мэргэжил” илтгэлийн уралдаанууд, болон спорт, урлагийн уралдаан, тэмцээн, олимпиадуудад анги хамт олноороо болон хувиараа оролцсон.
- Экологийн улсын олимпиадад 2015 онд 2-р байр, 2016 онд багаараа 2, 3-р байр эзэлж байсан.

- **Олон улсад магадлан итгэмжлэгдсэн дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь**
- 2009-2015 онд БОХТ хөтөлбөрөөс ОХУ, БНСУ, Япон улсад нийт 7 оюутан хос хөтөлбөрөөр суралцаж төгссөн байна.
- Цаашид Хятад, Солонгос, Орос, Япон, Австр, Герман зэрэг улсын их сургуулиудтай хамтран ажиллахаар төлөвлөж байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй**

**Анхаарах асуудал:**

- Хамтарсан хөтөлбөрийн баталгаажуулалтанд анхаарах

**Зөвлөмж:**

- Баталгаажуулсан хамтарсан хөтөлбөр болон гэрээг тайланд оруулах

#### **7.4. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

**Үзүүлэлт нотолгоо:**

- **Хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар олон нийтийг үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллээр тогтмол хангадаг байдал**
- 2014 он хүртэл зөвхөн элсэлттэй холбоотой мэдээллийг гаргадаг байсан бол түүнээс хойш хөтөлбөртэй холбоотой бүх мэдээллийг ил тод гаргадаг болсон.
- Олон улсын хамтарсан хөтөлбөрүүдээ харьцуулалт хийн сайжруулж, багш нар олон улсын импакт бүхий сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн байна.
- Улсын хэмжээнд радио, сонин, телевизээр мэргэжлээ сурталчлах, уралдаан тэмцээнд оролцдог.
- ХААИС-ийн хэмжээнд сургуулийн цахим хуудас, багшийн ба оюутны программ хаягаар мэдээллийг хүргэдэг.
- **Вебсайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа**
- ХААИС-ийн мэдээлэл технологийн албанаас 2010 оноос хойш цахим хаягийг 3 удаа шинэчлэн сайжруулсан.
- Оюутны цахим бүртгэл, онлайнгаар хичээл сонголт хийх, номын сангийн катологийг хаанаас ч үзэх боломжтой болсон.
- Веб сайтад тухайн хөтөлбөртэй холбоотой мэдээллийг Мэдээлэл технологийн албанд хүргүүлснээс хойш 1-2 цагийн дотор нэгтсэн сайтад байрших боломжтой болжээ.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Улсын хэмжээнд мэргэжлээ сурталчлах, мэргэжлийн талаар танилцуулгыг маш сайн хийдэг.

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн давуу тал, дутагдал, хэрэгжүүлэхэд гарч байгаа хүндрэлтэй асуудлуудыг тодруулан тодорхойлж дүгнэж байх.

**7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Шалгуур 8. Чанарын үнэлгээ, баталгаажилт**

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

**8.1. Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээг тогтмол, давтамжтай хийдэг байна.**

**Үзүүлэлт нотолгоо:**

- **Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуултыг хангах удирдлага, зохион байгуулалтын шийдэл, үр дүн**
- ХААН КАМПУС хөтөлбөрийг 2010 онд боловсруулан мөрдсөн.
- 2010 оноос чанарын үнэлгээний механизм стратеги төлөвлөлт, стратегийн үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн хяналт, үнэлгээ гэсэн 3 үе шаттайгаар хэрэгжиж, стратеги төлөвлөлт нь 2010-2016, 2016-2021 гэсэн 2 үе шатаар хэрэгжиж байна гэжээ.
- Жил бүр багш, оюутан, ажил олгогч зэрэг хөтөлбөрт оролцогч болон сонирхогч талуудаас судалгаа авч дотоод чанарын баталгаажуулалт хийдэг байна.
- Дотоод чанарын баталгаажуулалтын байгууллага нь 2006 оноос хойш 5 удаа шинэчлэн өөрчлөгдөж 2016 оны 04 сараас дотоод аудит, 2017 оны 01 сараас хяналт шинжилгээ, чанар хариуцсан мэргэжилтний бүрэлдэхүүнтэйгээр ажиллах болсон байна.
- 2014 оноос хөтөлбөрийн хороо байгуулагдан ажиллажээ. Хөтөлбөрийн хорооны чанарын баталгаажуулалтыг хангах удирдлага зохион байгуулалтын шийдлийг бүдүүвчээр харуулсан байна.
- **Дотоод чанарын баталгаажуулалтын тогтсон бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ**
- ХША дотоод аудит, хяналт, шинжилгээний цаашдын чиг хандлага хэлэлцүүлэг зохион байгуулж байжээ.
- Ажлын хэсэг байгуулж чанарын баталгаажуулалтын журмын төсөл боловсруулсан (сэтгэл ханамжийн судалгааны маягтуудыг хавсаргасан) байна.
- 1.Бодлого, 2. хөтөлбөр, төлөвлөгөө, 3. Хэрэгжилт, 4. Үнэлгээ гэсэн байдлаар тайланд товч оруулах хэрэгтэй.
- БОХТ хөтөлбөрөө 7 шинжүүрээр зохих түвшинд байна гэж үнэлсэн байна.
- **Дотоод чанарын баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоо**
- 2017 онд төгсөгчдийн талаарх сэтгэл ханамжийн судалгаанд 112 ажил олгогч байгууллагын төлөөл хамрагдаж ажил эрхлэлт, ерөнхий мэдлэг, ур чадварт үнэлгээ өгсөн байна.
- **Хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрч чадсан эсэхийг мэдээ баримтад тулгуурлан дүгнэж өөрийн үнэлгээг хийдэг байдал**
- Хөтөлбөрөөр бэлтгэгдсэн мэргэжилтэн нийгэм эдийн засгийн хөгжлийг экосистемийн даацад тохируулан байгаль орчны тэнцлийг хангах, байгалийн баялагийн нөөцийг зөв тогтоох тогтвортой ашиглах, хяналт шинжилгээ, экологи эдийн засгийн үнэлгээ хийх, ногоон хөгжлийг дэмжих, тогтвортой хөгжлийг хангах, хүний эрүүл мэнд, байгаль орчинд аюулгүй, шинжлэх ухааны үндэстэй технологи, үйлдвэрлэлийг үр ашигтайгаар эрхлэх мэргэжлийн мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байдал, ажлын үр дүнг ажил олгогчдын ба төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгааны үнэлгээгээр үнэлдэг байна.
- Судалгааны үр дүнг мэргэжил бүрээр оруулсан байна.
- **Хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах зорилгоор судалгааны үр дүнг хөтөлбөрийн ахиц, дэвшилд системтэйгээр ашигласан байдал**
- БОХТ мэргэжлийн хөтөлбөрийн идэвхжүүлэлтийн төлөвлөгөөний дагуу судалгаанд хамрагдсан хот, бүс, аймаг, хөдөө орон нутагт байгаа төгсөгч, ажил олгогч болон суралцагч, багш нараас сэтгэл ханамжийн судалгааг 2015 онд 2 бүлэг 45 асуулт, 4 бүлэг бүхий 70 асуултаар тус тус авч үр дүнг нэгтгэн шинжилгээ хийж гаргасан дүгнэлтэнд тулгуурлан өөрийн үнэлгээг хийж, шинэчлэлд тусгадаг байна.
- **Хөтөлбөрт орсон өөрчлөлтүүдийн үр нөлөөг хянасан байдал**
- 2015 онд батлагдсан сургалтын төлөвлөгөөний өөрчлөлтийн дагуу төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдийн хөтөлбөрүүдийг нэгдсэн загварт оруулан агуулгыг хянаж хорооны хурлаар хэлэлцэж давхардлыг арилган ажилладаг байна.

- БОХТ хөтөлбөрөөр эзэмших ур чадварын үзүүлэлтүүд хөтөлбөрийн эрхэм зорилт, зорилгуудтай хэрхэн нийцэж байгааг харуулсан байна.
- Сургалтын хөтөлбөрийн чанарын үнэлгээ, баталгаажуулалтад SWOT шинжилгээ хийсэн байна.
- **Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд эргэх холбоо үүсгэх**
- Энэ талаар тайланд оруулаагүй боловч багш нар болон төгсөгчидтэй хийсэн уулзалтын явцад төгсөгчид сургууль тэнхим, багш нартайгаа эргэх холбоотой зарим талаар хамтран ажилладаг нь харагдаж байлаа. Төгсөгчдийн холбоо байгуулахаар төлөвлөн ажилаж байгааг баталгаажуулах хэрэгтэй.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй**

**Онцлог зүйл/Туршлага:**

- 2010 оноос хойш ХААН кампус хөтөлбөрийг хэрэгжүүлэх болсон.

**Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг хариуцах алба мэргэжилтнийг тодорхой болгох

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын шинэ журмын төслөө баталгаажуулан хэрэгжүүлэх хэрэгтэй.
  - 1.Бодлого, 2. хөтөлбөр, төлөвлөгөө, 3. Хэрэгжилт, 4. Үнэлгээ гэсэн байдлаар тайланд товч оруулах хэрэгтэй.
  - Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд эргэх холбоо үүсгэх талаар тайланд оруулах

**8-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

**Шинжээчийн дүгнэлт: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй**

### **ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ЭЦСИЙН ДҮГНЭЛТ:**

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Хөдөө аж ахуйн их сургуулийн Агроэкологийн сургуулийн “Байгаль орчныг хамгаалах технологи” бакалаврын сургалтын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна. Шинжээчийн багийн дүгнэлтийг Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлтийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг ...../Д.Нармандах/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Ж.Цэен-Ойдов/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Ю.Дэлгэрмаа/

**Хавсралт 1**

ХААИС-ийн Агроэкологийн сургуулийн Байгаль орчныг хамгаалах технологи бакалаврын сургалтын хөтөлбөр дээр ажиллах шинжээчдийн ажлын хуваарь

2018 оны 2 дугаар сарын 08, 09

Хугацаа	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн
<b>2018-02-08 Пүрэв гараг</b>		
09:00-10:30	<b>Зохицуулагч шинжээчийн багийг танилцуулна</b>	<b>Зохицуулагч</b>
	<b>Шинжээчийн багийн ахлагч үг хэлнэ:</b> - Магадлан итгэмжлэлийн үйл явц, хуваарийг танилцуулах	<b>Шинжээчийн багийн ахлагч</b>
	<b>Сургуулийн захирал үг хэлнэ</b>	<b>Өөрийн үнэлгээний багийн ахлагч</b>
	<b>Удирдлага болон ӨҮ-ний багтай уулзах:</b> - Удирлагын бэлдсэн хөтөлбөрийн товч танилцуулга	<b>Шинжээчийн багийн ахлагч</b>
10:30-12:00	<b>Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой шинжээчид танилцана</b>	<b>Шинжээчид</b>
12:00-13:00	<b>Сургуультай танилцах аялал /Анги танхим, лаборатори, номын сан, студи г.м/</b>	<b>Шинжээчид</b>
13:00-14:00	<b>Өдрийн хоол</b>	
14:00-16:00	<b>Оюутнуудтай хийх уулзалт</b>	<b>Шинжээчид</b>
16:00-17:00	<b>Ажил олгогчидтой хийх уулзалт</b>	<b>Шинжээчид</b>
17:00-18:00	<b>Төгсөгчидтэй хийх уулзалт</b>	<b>Шинжээчид</b>
<b>2018-02-09 Баасан гараг</b>		
09:00-10:00	<b>Өөрийн үнэлгээний тайлангийн нотлох баримттай танилцах</b>	<b>Шинжээчид</b>
10:15-11:15	<b>Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах</b>	
11:30-12:30	<b>Багш нартай хийх уулзалт</b>	
12:30-13:30	<b>Өдрийн хоол</b>	
13:30-14:30	<b>Өөрийн үнэлгээний тайлангийн нотлох баримттай танилцах</b>	
14:30-17:00	<b>Шинжээчид дүгнэлтээ хэлэлцэн гаргана. Нэмэлт материал үзэх танилцах /Бүрэн хангасан, хэсэгчлэн хангасан, хангаагүй/</b>	
17:00-18:00	<b>Шинжээчдийн баг магадлан итгэмжлэлийн эцсийн шийдвэрийг бус, урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэнэ.</b>	<b>Шинжээчийн багийн ахлагч</b>



## V. Оролцогчдын нэрс

## I. Ярилцлагад оролцсон багш нарын нэрс.

Д/д	Багшийн нэр	Албан тушаалын зэрэглэл	Зэрэг, цол
1	Т.Оюунчимэг	Профессор	Доктор, профессор
2	Х.Баярмаа	Дэд профессор	Доктор, дэд профессор
3	А.Энхтөр	Ахлах багш	Доктор
4	Б.Минжмаа	Багш	Магистр
5	Н.Мягмарсүрэн	Дагалдан багш	Магистр

## II. Оюутны нэр

## Оюутнуудын төлөөлөл

№	Анги	Оюутны нэр	Курс	Тайлбар
1	Байгаль Орчны Хяналт Үнэлгээ	Э.Цэнгүүн	4	АЭС-ийн оюутны зөвлөлийн гишүүн. Улаанбаатар
2		У.Азжаргал		Архангай
3		Б.Баттуяа		Архангай
4		Б.Гаваа		АЭС-ийн оюутны зөвлөлийн гишүүн. Дундговь
5	Байгаль Орчны Хяналт Үнэлгээ	Б.Болорцэцэг	3	Дорнод
6		О.Цолмонтуяа		Улаанбаатар
7		О.Сүхбат		Өмнөговь
8		С.Дорждэрэм		Говь-Алтай
9	Байгаль	Б.Жавзандулам		Өмнөговь
10	Орчны Хяналт Үнэлгээ	Г.Саруул	2	Улаанбаатар
11	Байгаль Орчны нөхөн сэргээлт	Г.Гэрэлцэцэг	4	Дорноговь
12		Э.Хангай		Улаанбаатар
13		А.Бат-Эрдэнэ		Булган
14	Байгаль Орчны нөхөн сэргээлт	Н.Ууганхүү	3	Увс
15		М.Жавзан		Хөвсгөл
16		Ш.Үүрийнтуяа		Хөвсгөл
17		Д.Өлзийсайхан		Хөвсгөл
18	Байгаль Орчны нөхөн сэргээлт	Б.Энхмаа	2	Ховд
19	Байгаль Орчны нөхөн сэргээлт	Д.Ганболд	1	Улаанбаатар

### III. Төгсөгчид

#### Байгаль орчныг хамгаалах технологи хөтөлбөрөөр төгсөгчдийн төлөөлөл

№	Овог	Нэр	Мэргэжил	Ажил эрхлэлтийн байдал	Утас
1	Алтанхуяг	Баяртулга	БОНС	"Монполимет ХХК"-д Байгаль орчны нөхөн сэргээлтийн мэргэжилтэн	95090194
2	Эрдэнэбат	Баянзул	БОНС	Мөнх ногоон хэрэмд Дүүрэг хариуцсан хяналтын мэргэжилтэн	99054299
3	Буянхүү	Өлзийбат	БОНС	"Уулс заамар " уул уурхайн компанид мэргэжилтэн	99620501
4	Ганбаатар	Балдангомбо	БОНС	"Арвижих Энерги" ХХК-д уул уурхайн компанид байгаль орчны мэргэжилтэн	99615832
5	Намнан	Оюун-Эрдэнэ	БОХУ	Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар БО-ны хяналтын улсын байцаагч	99141521
6	Сундуйхүү	Сайнбаяр	БОХУ	Монголын үндэсний их сургуульд багш	88043013
7	Сүхбат	Нямжав	БОХУ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт БО-н хяналтын улсын ахлах байцаагч	99096172 99999155
8	Даштогтох	Төмөрцоож	БОХУ	УЦУОМСХүрээлэнд ЭША	91030227 88091246
9	Аниган	Болат	БОХУ	"Газар чандмань " ХХК-д үнэлгээний компанид мэргэжилтэн	95100426
10	Түгжжав	Билгүүнтөгс	БОХУ	Монголын үндэсний их сургуульд багш	99686356
11	Нэргүй	Жүгдэрнамжил	БОХУ	Зэрлэг амьтан судлах төвд мэргэжилтэн	88838800
12	Мөнхсайхан	Хоролсүрэн	УНБҮ	МААЭШХ, Эрдэм шинжилгээний туслах ажилтан	99249275
13	Зоригбаатар	Нямцэрэн	УНБҮ	ХААИС-ийн Экоситемийн судалгааны төв. Эрдэм шинжилгээний ажилтан	99834521
14	Цэдэн-Иш	Нарангэрэл	УНБҮ	ХААИС-ийн Экоситемийн судалгааны төв. Эрдэм шинжилгээний ажилтан	88039294
15	Баянжаргал	Жавзандорж	УНБҮ	ХААИС-ийн ЭЗХА, Ногоон байгуулжмийн мэргэжилтэн	88034633
16	Б.Баттогтох	Баярмаа	УНБҮ	МААЭШХ, БТСалбарт Эрдэм шинжилгээний дэд ажилтан	88066552
17	Батаа	Мэндбаяр	УНБҮ	"Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон хөдөөгийн амьжиргаа төсөл" (JFPR 9164-MON) Бэлчээрийн мэргэжилтэн	99783553
18	Батжаргал	Батсүх-Очир	БОХУ	ШУТИС-ДТҮЭХ-нд эрдэм шинжилгээний ажилтан	8897262
19	Баттөр	Хишигсүрэн	БОХУ	Дунар-Од ХХК-ийн усны үнэлгээний мэргэжилтэн	88589208
20	Бат	Батзаяа	БОХУ	"ЖЭМР" ХХК-д байгаль орчны үнэлгээний компанийн захирал	99238243

#### IV. Ажил олгогч

#### Ажил олгогчдын төлөөлөл

№	Нэр	Байгууллагын нэр	Албан тушаал	Утасны дугаар
1	Б.Мөнхнасан	Монголын үндэсний их сургууль	Салбар сургуулийн захирал	90196908
2	Н.Оюун-Эрдэнэ	Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар	Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар байгаль орчны хяналтын улсын байцаагч	91902025
3	Л.Өлзийбаяр	"Ашид эко" ХХ компани	Захирал	99086190
4	З.Ундрах-Эрдэм	МЕРА групп	Байгаль орчны алба хариуцсан дарга	99904046
5	Б.Батцэцэг	МҮИС	Тэнхимийн эрхлэгч	88081813
6	Б.Батзаяа	ЖЭМР" ХХК	Захирал	99238243

#### VI. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/

#### VII. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо) .....  
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

**Зөвлөмж /Recommendations/**

#### VIII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)  
..... [Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

**Зөвлөмж /Recommendations/**